Манай багш оюутан бүхэнд нэжээд ном, хошоод дэвтэр, турваад үзэг, дөрвөөд харандаа өгөв. Одоо та хаанаас ирэв? Би уншлагын танхимаас ирэв. Тэнд олон хүн байна уу? Одоо уншлагын танхимд зуугаад хүн ном ба сонин уншиж байна. Барагцаалбал тэдний дөрвөний нэг хувь бол багш нар ба албан хаагчид байна. Тэнд цөөн биш, олон хүн сууж байна.

Одоо Дамдин, Дорж, Жамц гурвуул зугаацаж явна. Тэдэнтэй таван оюутан уулзвав. Тэдгээр оюутан нар наймуулаа манай дээд сургуулийн оюутан нар юм. Тэдгээр оюутан нар наймуул кино үзэв!

Манайд нэхэр Самдан ирэв. Би түүнтэй ярилцав. Нэхэр Самдан бол: “Чиний өвгөн аав эмэг эх хоёр хэдэн настай вэ?” гэж асуув. Миний өвгөн аав ерэн хоёр настай, миний эмэг эх наян таван настай юм гэж би хариулав. Таны хүү, охин хоёр хэддүгээр ангид сурч байна? Манай хүү наймдугаар ангид сурч байна. Манай охин нэгдүгээр ангид сурна.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хүн амын тоо хэд вэ? Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хүн амын тоо есөн зуун мянга гаруй юм. Өөрөөр хэмбэл есөн бүм гаруй болно. Монгол ардын хувьсгал хэдэн онд мандав? Монгол ардын хувьсгал нэг мянга есөн зуун хорин нэгдүгээр онд мандсан юм. Энд сууж байгаа нэхэр Монгол ардын хувьсгалын тухай илтгэл хийх гэж байна.

Энэ жил бол мянга есөн зуун жаран хоёрдугаар он юм. Өнөөдөр хэдэн бэ? Өнөөдөр мянга есөн зуун жаран хоёрдугаар они долоодугаар сарын хорин нэгэн юм. Цаг хэд болж байна? Долоон цаг хагас болоод байна. Орой болжээ. Тийм! Чи хожимдож ирсэн. Өршөөнө үү, би танд саад болчлоо.

Одоо цаг хэд болж байна? Арван цаг болоод байна. Бид энд хоёр цаг хагас суув. Одоо бид гэртээ харина. Та бидэнтэй шатар нэг нүүнэ үү? Үгүй, би чадахгүй. Би маргааш танайд ирье! За, тэгье!

Би хувцсаа өмсөв. Миний өрөөсөн бээлий хaa байна? Чиний өрөөсөн бээлий энд байна. За, явъя! Сайн яваад ирээрэй!

LESSON 12

12. 1. Converbs in -магц and -хлаар

The converbs formed with the suffixes -магц and -хлаар are rather close in meaning. In general they convey the sense 'as soon as'.

a. -магц (-МОГЦ, -МЭГЦ, -МӨГЦ) signifies that as soon as one thing has occurred, another takes place; in other words, one occurrence immediately followed by another.

b. -хлаар (-хлоор, -хлээр, -хлеэр) with a corresponding short vowel inserted between the stem and the suffix, signifies that one action takes place immediately after the other action has begun.

12. 2. Converb in -саар

The converb formed with the suffix -саар (-соор, -сээр, -сээр) signifies a continuing action that has been going on since the beginning of the main action. With the auxiliary verb байх 'to be' it carries the meaning 'keeps on, goes on, continues to'

ирсээр байна

keeps coming

мэлхэсээр байв

he went on slipping

Зураг зурсаар шене
орой болтол суув.

He sat drawing pictures until
late at night. (He sat until it
became late at night, continuing
to draw pictures throughout
the act of sitting.)

12. 3.

In addition to the verbal suffixes that have been discussed, the stem of the Mongolian verb can be expanded by suffixes that give the basic root passive, causative, and other meanings.

12. 4. The Passive

The passive is formed by these suffixes:

- a. -Т if the stem ends in Р, Г or В that is not followed by an unwritten short vowel:

өг-	өгтэх	to be given
ав-	автах	to be taken
гар-	гартах	to be overtaken

- b. -Д if the stem ends in Л (without a hidden final short vowel):

ол-	олдох	to be found
дайл-	дайлдах	to be conquered

- c. -ГД in all other cases; if the stem ends in a consonant, a short vowel corresponding to the vowel quality of the stem is inserted:

нээ-	нээгдэх	to be opened
мэд-	мэдэгдэх	to be known
сонс-	сонсогдох	to be heard (one sometimes also sees the form сонсдох)
ал-	алагдах	to be killed

12. 5.

The logical subject of a passive phrase is put in the dative case:

нохойд идэгдсэн мах	the meat eaten by the dog
Тарвага чи хэцүү юм бол яагаад хүнд ал- агддаг юм бэ гэжээ.	"Marmot, if you are so clever, why are you always killed by man?" he said.

12. 6. The Causative

Almost any Mongolian verb can be made causative by the addition of one of the following suffixes to its stem. The causative

indicates that someone causes or permits' an action to be done: сүүх 'to sit', but сүүлгах 'to seat, to have (someone) sit, to allow to sit, to cause to sit'. The causative suffix makes intransitive verbs transitive: хатаж 'to dry' (intrans.), хагаах 'to dry' (trans.)

би орондоо хэвтэв I lay in my own bed.

ээж намайг оронд минь
хэвтүүлэв Mother had me lie in my bed.

12. 7.

The following suffixes form the causative:

a. -лга- (-лго-, -лгэ-, -лгө-); added to stems ending in a long vowel or diphthong:

сүүх	to sit	сүүлгах	to cause to sit, to seat
------	--------	---------	--------------------------

хаах	to close	хаалгах	to cause to close, to allow to close
------	----------	---------	---

b. -га- (-го-, -гэ-, -гө-); added to stems in -л, -р, -с, -д (-д changes to -т before the suffix):

гарах	to come out	гаргах	to cause to come out, to produce
-------	-------------	--------	----------------------------------

хүрэх	to arrive	хүргэх	to cause to arrive, to supply, to send
-------	-----------	--------	---

босох	to rise	босгах	to raise
-------	---------	--------	----------

цадах	to become full	цатгах	to fill, to feed to satiation
-------	----------------	--------	-------------------------------

c. -аа- (-оо-, -ээ-, -өө-); added to some stems ending in a short vowel:

зогсох	to stop, to stay	зогсоох	to cause to stop, to cause to stay
--------	------------------	---------	------------------------------------

зовох	to suffer, worry	зовоох	to torment, to cause to worry
-------	------------------	--------	-------------------------------

сөнөх	to go out (of fire), сөнөөх to perish		to extinguish, to annihilate, to destroy
-------	---	--	--

d. -гаа-; added to a very few verbs ending in a short vowel:

унах	to fall	унагаах	to fell, to cause to fall
------	---------	---------	---------------------------

e. -үүл- (-үүл-); added to all other stems (after a few stems ending in a diphthong: -гуул-):

орох	to enter	оруулах	to introduce, to cause to enter
хэвтэх	to lie, lie down	хэвтүүлэх	to lay, to cause to lie
үзэх	to see	үзүүлэх	to show, to cause to see
цуглах	to gather (intr.)	цуглувулах	to gather (trans.)
байх	to be	байгуулах	to build, to organize

12. 8.

Occasionally the causative suffix will give a passive meaning:

заах	to teach	заалгах	to be taught, to be shown
------	----------	---------	---------------------------

12. 9. Reciprocal and Cooperative Forms

Verbs can be given a reciprocal meaning by the addition of the suffix -лд-:

алах	to kill	алалдах	to kill each other
барих	to grasp	барилдах	to wrestle, to stick together, to adhere

12. 10.

A cooperative action is expressed by the addition of the suffix -лц-:

сүүх	to sit	сүүлцах	to sit together, to live together, to participate
------	--------	---------	---

суралх	to study, learn	суралцах	to study together
хэвтэх	to lie	хэвтэлцэх	to lie together

12. 11.

The exact shades of meaning of the reciprocal and cooperative verbs are not always adhered to. They can be used simply to indicate an action in which many people take part, and in such cases they are interchangeable.

12. 12.

An action in which many people participate, an action performed in a group, is expressed by adding the suffix -цгаа-(-цгоо-, -цгээ-, -цгөө-):

явах	to go	явлцаах	to go (in a group)
суух	to sit	сүүцгаах	to sit (in a group)

12. 13. The Intensive

An intensive is formed by adding the suffixes -ч- or -чих- to the stem of the verb. This form indicates an action that is done completely and quickly, suddenly, and sometimes violently:

Санж босов	Sanj got up.
Санж босчихов	Sanj sprang up.
Жамба тэгээд усангүй мордоод явчихав.	Then Jamba mounted and took off without the water.

12. 14.

These suffixes can be added one to the other so that one may find the stem of a verb expanded by two, three, and even four of the suffixes:

гарах	to go out
гаргах	to cause to go out
гаргуулж	to have someone cause someone to go out

барих	to take, to grasp
баригдах	to be grasped
баригдуулах	to cause to be grasped

12. 15. The Verb орхих

The verb **орхих** 'to throw' is used as an auxiliary verb to indicate a complete and finished action, sometimes with a measure of speed and violence in the performance:

идэж орхи-	to eat up completely
уутанд хийж орхисон	whipped (me) into the sack

12. 16. The Verb өгөх

The verb **өгөх** 'to give' can be used as an auxiliary verb to indicate that an action is done for someone else:

заяж өг-	to show someone
хэлж өг-	to tell someone; to tell something for somebody's benefit
аваачиж өг-	to bring for someone

12. 17. The Verb авах

The verb **авах** 'to take' used as an auxiliary verb gives the opposite meaning of doing something for oneself:

аваачиж ав-	to bring for oneself
бичиж ав-	to write down for oneself

12. 18. The Verb үзэх

The verb **үзэх** 'to see' is used as an auxiliary verb together with an imperfect converb with the meaning 'to try to':

үүнийг барьж үзэв	he tried to grasp it
авдрыг онгойлгож үзвэл	when he tried to open the coffer

12. 19. Reading

ХААНЫ ШИНЭ ХУВЦАС - 2

Хаан өөрөө тэр эдийг үзье гэж нэгэн өдөр урьд очсон хоёр түшмэлийн хамт тэр хоёр луйварчны өмнө очсонд тэр хоёр хааныг үзээд утасгүй хоосон суурийн өмнө хамаг чадлаа гаргаж нэхэх дүрэм үзүүлэв. Хаан гайхаж “Аяа, энэ ямар жиг вэ? Миний нүдэнд юм огт үзэгдэхгүй байна. Би тэнэг манггуу билүү? Эсвэл, би хаан болбол тэнцэхгүй байна уу? Энэ ямар хэцүү хэрэг билээ” гэж бодоод өндөр дуугаар “Аяа, ютай сайхан эд вэ!” гэж хэлжээ.

Тэр хоёр луйварчин, заа хааны хувцас бэлэн боллоо гэсэнд хаан ирэв. Хоёр луйварчин юм барьсан байдал үзүүлэн гаралт өргөж “Үзэгтүн! Энэ бол өмд, энэ бол цамц, энэ бол нэмрөг; цем алзны шүлс мэт хөнгөн тул өмссэн хүн өмссөнөө огт мэдэхгүй, тийм сонин эрдэмтэй хувцас юм” гэж хэлэхэд хааныг дагасан олон түшмэд бүгдээрээ тиймээ! Гэвч тийм хувцас үнэндээ үгүй тул нүдээ бүлтийтэл дэний хоосон газар ширтэж байв.

Хоёр луйварчин хаанд шинэ хувцас өмсгэх байдал гаргаж аашлав. Хаан толины өмнө цааш нааш эргэж биеийг үзэв. Олон бүгдээр, аяа, энэ хувцасны өнгө хээ юутай үзэсгэлэн сайхан юм бэ? гэж хашгартал ёслол удирдах түшмэл ирж, гадаа их ёслолоор залрах төрийн их шүхрийг залж хаантныг хүлээж байна гэсэнд, хаан за, би бэлэн боллоо гэжээ.

Хаан төрийн их шүхрийн дор маш ихэмсэг байдлаар явахад гудамж зээлийн газар хуралдсан иргэн, “Ай, тэнгэр ээ, манай хааны энэ хувцас үнэхээр хосгүй сайхан хувцас байна” гэж хашгарцгаав.

Тэгж явтал гэнэт нэг бяцхан хүүхэд, “Аяа, манай хаан чармаа нүцгэн явж явна” гэж хашгарсанд эцэг нь дуудан, “Ай, тэнгэр ээ, гоёч үгүй үнэн үгийг сонсогтун” гэсэнд олон хүн тэр хүүхдийн хэлсэн үгийг бие биедээ сэм дамжуулан хэлсээр хурсан олон бүгд, энэ хаан хувцасгүй нүцгэн явж явна; тэр нэг хүүхэд хааныг улаан нүцгэн явж явна гэж хэллээ гэж хашгарцгаав.

Хаан олны хэлэлцэх тэр үгийг зөв гэж бодож олоод ихэд ичсэн боловч арга буюу нэгэнт ингэж гарснаас хойш хувцастай хүн шиг явахаас өөр мэхгүй болов гэж улам

ихэмсэг байдал гаргаж явахад хааны нэмрэгийн хормойг барих хүмүүс царайг төв болгож хормойг барих мэт гарыг өргөн явжээ.

12. 20. Notes

1. билүү: contraction of билээ + үү (interrogative particle)
2. хашгартал: 'when they shouted'; this suffix (see section 9.6-9.7) is often best translated as 'when...'.
3. хаантныг: contraction of хаантан + ыг 'your majesty' (accusative)
4. (тэнгэр) ээ: a vocative exclamation
5. хашгарцгаав: 'they shouted in unison' (see section 12. 10)
6. бие биедээ: 'to each other, from person to person'
7. хааныг: 'referring to the khan, with respect to the khan' (see section 15. 2)
8. улаан нүцгэн: 'stark naked' (lit.: 'red naked')

LESSON 13

13. 1. Comparative Degree

The comparative degree, as has already been shown (section 4. 2. a.), is formed by means of the ablative case. The ablative case suffix is added to the word which is the basis for comparison.

энэ байшинаас өндөр	higher than this building
төмөр бол модноос хатуу байна	iron is harder than wood
Улаанбаатраас их	bigger than Ulaanbaatar

13. 2. Superlative Degree

The superlative degree can be formed in several ways:

a. The words **хамгийн** and **түйлүүн** are used to form an absolute superlative:

хамгийн хол	the most distant
хамгийн их	the largest, the greatest
хамгийн сайн	the best
түйлүүн бага	the minimum, the least
түйлүүн сайн	the best

b. The superlative can be expressed by a noun in the genitive case followed by an attribute (which is the case also in the examples given in a. above; since these are the most common words used to form the superlative they are listed separately):

Халхын сайн эр	the best man of the Khalkhas
багачуудын дотно (найз нар)	the most intimate friends among the children

c. A superlative is sometimes expressed by an attribute in the genitive or ablative case followed by another attribute:

халуунаас халуун	the hottest, hotter than hot
мууцийн мүү	the worst, the worst of the bad.

13. 3.

A very high degree or intense degree is indicated by reduplication. The first syllable of the word is reduplicated with a final -в. If the first syllable ends in a consonant, this is replaced by -в. If the word begins with a vowel, this is reduplicated with a final -в:

улаан	red	ув улаан	bright red
хар	black	хав хар	coal black
шинэ	new	шив шинэ	brand new
чимээгүй	silent	чив чимээгүй	completely noiseless, dead silent

13. 3.

A high degree or intense quality is also expressed by intensifying particles like: маш 'very', тун 'extremely', нэн 'very, completely';

маш их	very big
тун мүү	extremely bad

13. 5. Diminutives

A diminutive is formed by the suffixes -хан, -втар, -шиг:

a. -хан (-хэн, -хон, -хэн) is the most frequently used diminutive suffix. It can be added to practically any noun, adjective, adverb, or even numeral. In most cases it adds the diminutive significance 'rather, -ish', but it is sometimes used without any translatable diminutive meaning (see the last example below). When this diminutive suffix is added to an attribute modifying a noun, the diminutive sometimes refers not to the attribute but to the noun.

шинэ	new	шинэхэн	newish
залуу	young	залуухан	youngish
хоёр	two	хоёрхон	only two
арваад	about ten	арваадхан	only about ten
	улаахан цэцэг		a red little flower (!)
	хархан малгай		a black little cap (!)
	шив шинэхэн		completely new, brand new (lit.: completely newish)

b. The diminutive suffix **-втар** (-втор,-втэр,-втөр) is used mainly with adjectives denoting colors:

улаан	red	улаавтар	reddish
ногоон	green	ногоовтор	greenish
цагаан	white	цагаавтар	whitish
настай	aged	настайвтар	rather old
хүйтэн	cold	хүйтэвтэр	coldish

c. The diminutive suffix **-шиг** is used infrequently:

урт	long	уртшиг	longish
гашуун	bitter	гашууншиг	rather bitter

13.6. Adjective-forming Suffixes

The suffixes most frequently used to form an adjective from a noun are **-т** and **-тай** (-той,-тэй):

хүч	power	хүчтэй/хүчит	powerful
үнэ	value	үнэтэй/үнэт	valuable
морь	horse	морьтой/морьт	equestrian, having a horse
гайхамшиг	curiosity	гайхамшигт	curious, strange
элс	sand	элстэй/элст	sandy
ус	water	устай/уст	watery

13. 7.

The suffix -гүй forms a negative attribute:

ус	water	усгүй	waterless
хүн	person	хүнгүй	deserted, uninhabited
үс	hair	үсгүй	bald
сээрэмж	attention	сээрэмжгүй	inattentive

13. 8. The Suffix -х,-хъ,-хи

The suffix -х, -хъ, -хи forms an attribute expressing location at or in something or existing at a specified time:

одоо	now	одоохъ	present
дотор	inside	доторхи	internal, inner
энд	here	эндэх	situated here
тэнд	there	тэндэх	of there, which is there
урд	front, south	урдахъ	southern, situated in front
урьд	formerly	урьдахъ	former

13. 9.

When added to a word in the dative case, the -х (-хъ,-хи) suffix expresses situation in or belonging to a certain place:

хотондохъ	situated in the city
далайдахъ	situated in the sea
огторгуйдахъ	situated in the sky

13. 10.

When added to the genitive case, the -х suffix indicates a belonging to the person or object in question:

эцэг	father	эцгийнх	belonging to father, some- thing of father's		
бид	we	манай	our	манайх	ours
Очир	Ochir	Замдаа	Очирынхыг үзэв.	On his way	he saw Ochir's (the thing or person belonging to Ochir)

13. 11.

The suffix **-ынхан** (-ийнхан, -нийхэн, etc.) which is by origin a plural of the suffix above, expresses a collective or group:

Улаанбаатрынхан	The Ulaanbaatarites
сургуулийнхан	those of the school (the students and staff)
төмөрзамынхан	the railroaders
шинжилгээнийхэн	the researchers

13. 12. Reading

ХОЁР САЙН МОРЬ

Эрт урьд цагт хол газар худалдагдсан хоёр морь уг нутгаа санаж харихаар гүйсээр явтал, тэр хоёр морины нэг нь замдаа нас хөгширч, харьж чадахгүй хоцрох болжээ. Залуу мориндоо ингэж захив:

- За, залуу дүү минь, замдаа сайн яваад хариарай. Хөгшин ах чинь одоо үхэх болов. Дүү минь болзоогүй замаар битгий яваарай! Бүргэлzsэн бор юман дээр битгий очоорой, боолттой юмны амыг битгий задлаарай гэж захиад хоцорч гэнэ. Залуу морь нь нэг бүдэг замаар орж явжээ. Гэтэл нэг бүргэлzsэн бор юмны бараа харагдаж гэнэ. Түүнийг очиж үзэх юмсан гэж, тэсч чадсангүй гүйн очиход уутанд хийсэн юмны ам нь боолттой хөдөлж байжээ. Түүний дотроос шу гарах бол үзэх юмсан гэж тэсч ядаад, амы нь

задалтал, дотроос нь өлссөн нэг том чоно гарч ирээд - чи юун морь ингэж миний боодлыг задлав. Би нэг айлын малаас барьж идсээр байтал тэр айлын хөрөнгөний эзэн намайг чиний адил хурдан мориороо хөөн гүйцэх барьж аваад, энэ уутанд хийж орхисон билээ. Одоо би чамайг идиэ - гээд барихаар завдан дагатал, нэг туулай явх байгаад, тэр хоёрыг үзмэгц: “Та хоёр юун морь чоно хоёр вэ?” гэж асуув. Тэхлээр нь үнэн байдал учраа тоочсонд тэр туулай морины амийг аврах аргыг бодож ингэж хэлж гэнэ: “Үгүй, чоно гуай ийм сайхан эр байтал, уутанд хийлгэх, ам нь боодолтой хэвтэж байна гэсэн чинь худал биз ээ. Хэрэв үнэн бол би харин энэ морин дээр өөрийнхөө биеийг шагн-алд нь өгч идуульье” гэв. Тэхэд нь чоно; үнээн, би энэ уутанд байсан гэж хэлжээ. Туулай “Эрхэм чоно та энэ уутанд яж багтах билээ, би үзээгүйдээ үнэмшихгүй.” гэжэд чоно, морь туулай хоёулангий нь идэхээр бодож, негее уутандаа дахин ороод, толгойгоо хараахан далд оруулаагүй байхад нь туулай: “За тэр толгой чинь багтахгүй байна гэж хашгармагц, чоно толгойгоо даруй далд оруулав. Туулай тэр даруй уутны амыг хуучин жэвээр нь боож орхив. Ингээд өчүүхэн биетэй боловч, арга онолтой туулайн гавьяагаар амь гарч, залуу морь нутагтаяа харьж амар сайхан харгасан гэнээ.

13. 13. Notes

1. нас хөгширч: 'growing old' (lit.: 'his age growing old')
2. замдаа сайн яваад хариарай: 'having gone well (without incident) return (home) !'
3. хоцорч: note that this is the short form of the finite past suffix -чээ (see section 8. 9a)
4. гэнэ: 'they say' -- a common feature of folk tales, where sometimes every sentence is so concluded.
5. бараа харагдах: 'to come into view, to get the first glimpse of in the distance'
6. хийж орхисон/боож орхив: see section 12. 14
7. тэхлэрээр нь: 'at once, right away' (lit.: 'as soon as he had done thus')

8. (биз)ээ: an emphatic particle

9. энэ морин дээр: 'in addition to this horse' (lit.: 'on top of this horse')

10. үнээн: 'it's true' -- vowel lengthened for emphasis

11. хоёулангий нь: an accusative of the word хоёул(ан) + нь (see section 8.8); the collective numerals are colloquially declined both with or without a hidden g.

12. тэр даруй: 'that instant'

13. хуучин хэвээр: 'in its old way; as it was before'

14. амь гарах: 'to remain alive, to escape danger alive'

LESSON 14

14. 1. The Suffix -маар

The suffix **-маар** (-моор, -мээр, -мээр) added to verbal stems forms an attributive expressing that the action is feasible and can be done:

идэх	to eat	идмоор	edible, fit to eat
авах	to take	авмаар	fit to be taken
олох	to find	олмоор	able to be found

14. 2.

The suffix **-шгүй** added to verbal stems expresses the negative of the above:

идэшгүй	inedible
уушгүй	undrinkable
олошгүй	unfindable

14. 3. Adverbs

Many adjectives can be used adverbially without any morphological change, e. g.: сайн 'good, well', чанга 'firm, firmly', but these and other adjectival words can be used specifically as adverbs with the addition of the instrumental suffix:

сайнаар	well
муугаар	bad, vilely
чангаар	firmly
хурднаар	swiftly

The instrumental case is, in fact, used to construct a multitude of adverbial expressions (see section 4. 4.).

14. 4.

The suffix **-үүр** (-үүр) is an adverbial suffix that indicates motion through the area above something or motion along, through something:

дээр	above	дээгүүр	through the area above
дор	below	доогуур	through the area below
хойно	behind	хойгуур	along behind, through the rear, north
цаанаа	on the other side	цаагуур	through and above the area yonder

14. 5.

The suffix **-ш** expresses motion in a certain direction:

дээр	above	дээш	upwards
дор	below	доош	downwards
цаанаа	beyond	цааш	away
наанаа	on this side	нааш/найш	to this side

14. 6.

A great number of adverbial particles are used in Mongolian to indicate the violence or thoroughness of an action. These are lexical items, but some examples of their use are given below:

цохих	to beat	бут цохих	to beat to pieces
дарах	to press	хуга дарах	to crush
татах	to pull	суга татах	to rip out
буудах	to shoot	цоо буудах	to shoot right through, to pierce

14. 7. The Suffix -с plus хийх

To indicate an abrupt and sudden action, the suffix **-с** is

used with some form of the verb хийх 'to do' (sometimes, but rarely, also with the verb гэх):

татах	to pull	татас хийх	to jerk
явах	to go	яvas хийх	to go suddenly
байх	to leave off	байс хийх	to quit suddenly

14. 8. Converb in -нгууд

A seldom used converb with the suffix **-нгууд** (-нгүүд, or **-нгуут/-нгүүт**) expresses that the action of the finite verb takes place during the action of the converb:

Санж замдаа явангууд
намайг үзэв.

While Sanj was going on his
way he saw me.

14. 9. Reading

РЭНЧИНДОРЖ ХҮҮ

Эрт урьд цагт Рэнчиндорж гэгч нэг хүү, аавтайгаа хоёулханаа суудаг байжээ. Нэг өдөр Рэнчиндорж айл хэсэж ааруул ээзгий гүйхаар бор даагаа унаж, богц хүүдий ганзгалаад явж байтал хааны аргалчин, үхэр тэрэг хетлеед явж байжээ. Тэгсэн чинь аргалчны тэрэгний боодой тасарчээ. Рэнчиндорж хүү буух боодой залгах байтал, хааны түшмэл давхих ирээд: Хаан чамайг аргал удаан түүлээ. Алчихаад ир гэж байна гэж аргалчинд хэлжээ. Гэтэл Рэнчиндорж хүү: Аргал удаан түүлээ гэж аргалчнаа алдаг юм байж, харин аргалаа даахгүй тасарч байгаа тэрэгнийхээ боодой яах бол? гэж асуужээ. Түшмэл ихэд уурлаж: Чам шиг муу юманд, хаан териийн ажил ямар хамаатай юм бэ? Чамайг хаанд аваачиж өгнө гээд ар талаас нь арав хорь өшиглэх, өмнө талаас нь өөд уруугүй алгадаж, хажуу таллас нь хавирга сүвээгүй нударч, түлхсээр Рэнчиндорж хүүг хаанд аваачиж өгөөд: Хаан ээний зарлиг ёсоор аргалчин хүүхнийг алх гэтэл, энэ муу хүү: Аргал удаан түүсэн аргалчныг хаан гуай алдаг юм байж, аргалаа даахгүй тасарч байгаа тэрэгний боодой яах бол гэж эгдүүтэй үг

хэлээд байхлаар нь аваад ирлээ гэжээ. Хаан: Тэгсэн нь үнэн юм уу? гэхлээр Рэнчиндорж хүү: Үнэн гэж хариулжээ. Хаан: Чи яасан мэргэн цэцэн үгтэй юм бэ! Чи энэ тогоон дээр чанаж байгаа цайг буцлахаас өмнө, үнсэн чедер зангидаад ир гэжээ. Рэнчиндорж хүү гарч урт өвс зулгаах чедер зангидаад хавтгай бансан дээр тавьж шатаагаад, үнсий нь тэр хэвээр нь хаанд барин очиж: За хаан гуай, хийгээд ирэхэд амархан хийлгэсэн эзэн хэрэглэхэд хэцүү энэ юмыг танд барья гээд үнсэн чедрэе банзтай нь хаанд өгчээ.

Хаан: Чи маргааш өглөө, эр үхэр сааж, элгэн тараг бүрж ир гэжээ. Рэнчиндорж хүү: Манайд хаантанд таарах аятай суулга пял байхгүй. Хаан өөрөө морилон очиж зооглоно уу? гэсэнд хаан: За, би маргааш очьё, чи яв гэжээ. Рэнчиндорж хүү хариад маргааш нь хааны ирж явах бараанаар хүрзээ шүүрэн авч, гэрийнхэс хаяаг манаж эхэлжээ. Хаан ирээд: Чи халуун зүн хаяагаа манаж байдаг учир юу вэ? гэхлээр Рэнчиндорж хүү: Ээ хаантан минь, аав минь хүүхэд гаргах гэж сандаргаад ядахдаа хаяагаа манаж байна гэжээ.

Хаан: Чи ямар тэнэг амьтан бэ? Эр хүн хэзээ хүүхэд гаргаж байсан юм бэ? гэжээ. Эр үхэр сааж, элгэн тараг бүрүүлэх гэж байгаа тэр хүн мён их ухаантай хүн байх нь ээ? гэж Рэнчиндорж хүү хэлжээ. Хаан юу ч хэлсэнгүй бодож бодож: Чи маргааш өдөр ч биш, шене ч биш, манай гэрт ч биш, гадаа ч биш, өөх ч биш, мах ч биш зүйлийг надад аваачиж өг. Хэрэв чадахгүй бол толгойгий чинь авна гэжээ. Рэнчиндорж хүү: Чадвал та яах вэ гэжээ.

Хаан: Чамайг чадвал хаан ширээндээ суулгана гэжээ. Рэнчиндорж хүү маргааш нь үүр шенийн завсраар хааныд очиж, гэрийн нь хатавчаар шагайгаад: За хаантан минь би өдөр ч биш шене ч биш ирээд, танай гэрийн гадаа ч биш, дотор ч биш байж байна. Хаан та өөх ч биш, мах ч биш энэ нэг юмыг авна уу? гэжээ. Хаан гараад харвал өдөр ч биш, шене ч биш, үүр шенийн завсрлын үе байжээ. Рэнчиндорж хүүг харвал хатавчаар шагайгаад, гадаа ч биш, гэрт ч биш, зогсох байна гэнэ. Өгсөн юмы нь үзвэл өөх ч биш, мах ч биш булчирхай байжээ.

Тэгээд хаан буруу харж уйлж, зөв харж инээж байж Рэнчиндорж хүүд хаан ширээгээ өгчээ.

14. 10. Notes

- Хаан чамайг аргал удаан...: 'concerning you, the khan said. . .'; 'you' is here in the accusative case, being the object of the statement.

2. ... яах бол: 'what about the ...', 'what will one do about...'
3. ар талаас нь... эшиглөж...: 'kicking him... from the back, ... slapping him... from the front'; note the idiomatic use of the ablative in these expressions
4. өөд уруугүй/хавирга сүвээгүй: 'both up and down' etc.
(see section 7.13 for this type of construction)
5. тогоон дээр: 'in the cauldron' (lit.: 'on the cauldron')
6. маргааш нь: 'the next morning' (lit.: 'its morning')
7. хааны... бараанаар: 'together with the khan's...';
i.e., 'at the moment the khan came into view...' (see section 4.4.h)
8. хаяаг манаах: 'to secure the lower part of the yurt',
i.e., to throw up a ridge of earth against the bottom of the yurt
to insulate and keep cold draughts from blowing in under the edge
of the felt.
9. юу ч хэлсэнгүй: 'didn't say a thing'
10. чамайг чадвал: the subject in the accusative case
(see section 15.1)
11. үүр шенийн завсраар: 'during the interval between
night and dawn' (see section 4.4.c)
12. буруу харж уйлж, зөв харж ишээх: This is a standard
closing phrase in folktales describing the dilemma of the person
who is tricked or defeated in the story.

LESSON 15

15. 1. Logical Subject of Non-Finite Verbs

The logical subject of a phrase in which the predicate is a non-finite verbal form may be put into various cases: nominative, genitive, accusative, or ablative:

бороо орвол	if it rains
би явбал	if I go
миний явбал	if I go
намайг явбал	if I go
түүнийг ирэхэд	when he comes
миний үзсэн морь	the horse that I saw
түрэмгийлэгчдээс	when the aggressors occupied
Монгол орныг эзлэхэд	Mongolia
Чойбалсангаас бичсэн	a work that Choibalsan wrote,
зохиол	a work written by Choibalsan

15. 2. Accusative of Reference

In statements or commands, the person or object referred to is often expressed in the accusative case with the significance 'with respect to, concerning':

Намайг маргааш ирээрэй
гэж хэлжээ.

He said that I should come
tomorrow (with respect to
me, he said...)

Доржийг одоо адуундаа
яваач гэж хэл.

Tell Dorj to go to his horse-
herd now (with respect to
Dorj, say...)

15. 3. Onomatopoeic Words

In Mongolian there are innumerable onomatopoeic words that express sounds and motions. They are usually combined with some form of the verbs ГЭХ 'to say' or ХИЙХ 'to do':

пул хийх	to plop (into liquid)
сар сар гэх	to rustle (with an even sound)
сар сур гэх	to rustle (with an uneven sound)
дав дав хийх	to shudder
далбас далбас гэх	to quiver
тэнтэр тунтар алхлах	to walk sideways and awry

15. 4. Binoms

Binoms are peculiarly common in Mongolian. Where one word would be sufficient to express the meaning, the Mongol often uses two synonyms side by side. Two words of opposing meanings are sometimes combined to form a new concept or term:

эв найрамдал	concord, friendship, peace
арга хэмжээ	means, measures
соёл боловсрол	culture
халуун хүйтэн	temperature (lit.: heat-coldness)
өндөр навтар	altitude, height (lit.: high-low)
орлого зарлага	budget (lit.: income-expenditure)

15. 5. Reading

БУХ ХУЦ УХНА ГУРАВ

Урьд нэг айл байжээ. Шуурганд больж зүдэрсэн бух, хуц, ухна ийм гурван амьтныг нутаг дээрээ хаяад нүүх болжээ. Тэр айлын нутаг дээгүүр нэг бар давхиж яваад, өнөөх гуравтай дайралджээ. Бар бухнаас асуужээ:

“Чиний нэр хэн гэдэг вэ? Чиний ёнэ толгой дээрхийг юу гэдэг юм бэ? гэхэд бух: “Миний нэр гүзээ ихт Гүнд хаан гэдэг, миний толгой дээрх бол тэнгэрээс хайлласан хар жад” гэжээ. Бар, бухын тэмсийг үзээд: “Чиний энэ шу вэ?” гэж асуусанд, бух: “Миний энэ бол аав, зэжээс хайлласан гашуун сонгино” гэжээ. Бар баахан сэжиглэж худнаас асуужээ: “Чиний нэр хэн гэдэг вэ?” гэхэд хуц: “Толгой ихт Тонж хаан” гэдэг гэв. Ухна ишигнээс асуужээ: “Чиний нэр хэн гэдэг вэ?” гэхэд ухна ишгийн хариулсан нь: “Сахал ихт Санж хаан” гэдэг гэв. Тэмсий нь үзээд: “Чиний энэ шу вэ?” гэж асуув. “Бардах ирсэн барын махыг амталж идэх гашуун сонгино” гэхэд нь толгой дээрх эврий нь бар хараад: “Чиний энэ шу вэ” гэж асуув. “Миний энэ бол эргээд ирсэн барыг эргэлтгүй цохидог эрчит хар муна” гэжээ. Бар ихэд айгаад тэднийг идэх чадсангүй явжээ. Замд нь нэг баавгай дайралдаад: “Бар гуай, та юунд ингэж давхив?” гэжээ.

Энд нэг айхавтар гурван хаан байна” гэсэнд, баавгай: “Ээ! Тэр юуны чинь гурван хаан байх вэ? Хоёулаа очиж идье” гээд, тэдэн тийш очиж явтал ухна ишиг өмнөөс нь дэвхцэж зандрал бархирсан нь: “Муу бар чамайг би чамд олигтойхон тарган баавгай авчир гэж хэлсэн үгүй юу” гээд, тэдний зүг учиргүй давхихад, бар зугтажээ. Хойноос нь давхисан ухна ишиг мөсөн дээр халтираад аарцгаа хагалж орхив. “Чамайг даа, та хоёртыг даа, өмдний тэлээ тасраагүй бол турсгы чинь хуулах сан!” гэж хашгарсаар тийчилж байв. Иймд хээр гараад, бар хэлсэн нь: “За одоо сахал ихт Санж хаантны өмдний тэлээ тасарчээ. Тэгээгүй бол одоо чи бид хоёр байхгүй сан. Больё одоо, тэр рүү зүглэхээ зогсьё. Ууланд очиж герөөс барьж идье” гээд явж байтал замд нь нэг чоно давхих явав. Тэр чоно гэнэт зог тусч “Бар гуай, та юунд их бачимдах давхив?” “Чамд хэлэх байтугай, сахал ихт Санж хаанд бараалхаж, буруу яландаа орох шахаад арайхийж амь мултрав” гэжээ.

“Үхсэн хойноо эцгийн чинь өв хаана байдаг юм бэ. Би одоо очиж идиэ” гэж чонын хэлэхэд: “Хай хай горьгүй байгаа. Би очихгүй” гэв. “Би тэр муу ухнаас айхгүй, та намайг итгэхгүй бол хоёулаа холбоотой явъя” гэлээ.

Ингээд хоёулаа холбоотой очиж явтал, өшөөх ухна ишиг мөсөн дээр босч чадахгүй, салтаа хагархай хэвтсээр байлаа. “Барыг хаантан харвал, харж байг. Би очихгүй, өмднийхөө тэлээ залгаж амжаагүй байна” гэж ухна ишиг

тийчилж байтал. “Тонж хаантан аа! Гараад ирээрэй. Тэнгэр тулсан хар жадаараа эднийг шалавхан алаад орхи” гэж ухна хашгармагц, хуц гарч ирээд: “Эргээд ирсэн барыг эргэлтгүй цохидог, эрчит хар муна чинь яв” гээд давхив. Ухна ишиг: “Би одоо өөрийнхеөрөө энэ барыг цохихгүй, харин гашуун сонгиноороо махы нь дүрж идье” гэж байв гэнэ. “Ээ тэгвэл минийх байна” гээд хуц месен дээгүүр давхиад орхисон чинь эврээ хуга ойчжээ. Бар “Юу идэхээ алд” гээд ум хумгүй зугтажээ. Хуц эргээд: “Муу хар жадны үзүүр мохчихжээ. Билүүдэх гэсээр байг-аад хождов” гэлээ. Баранд чоно чирэгдсээр шүд нь ярзг-анаж үхэв.

Бар түүнийг эргэж хараад: “Чамд инээд, надад ханиад болж байна” гэж уурлан давхиж алст гарсан хойно сая чоныг харвал, чоно аль хэдийн үхсэн байжээ. Араатан амьтны ч хоол болсонгүй, нэг нь салтаагаа хагалсан, негее нэг нь эврээ хугалсан, ийм гурван амьтан ногоо гарсан хойно гэртээ эргэж харив гэнэ.

15.6. Notes

1. нүүх болжээ: '(they) were about to transhume'
2. бухнаас асуужээ: 'asked the bull'; the verb 'to ask' requires the ablative case
3. Чиний нэр хэн гэдэг вэ: 'What is your name?'
4. толгой дээрхийг: 'that which is on (your) head'
5. гүзээ ихт: 'having a large rumen'
6. тэнгэрээс: see section 4.2.d
7. замд нь: 'on his way'
8. тэдэн тийш: 'toward them' (see section 8.7)
9. өмнөөс нь: 'towards them' (lit.: 'from in front')
10. ...үгүй юу: 'I didn't say... did I?'
11. хагалж орхив: see section 12.14; this auxiliary verb recurs frequently in this reading selection
12. хуулах сан: 'I would have flayed'; this is the past verbal noun in -сан of the defective auxiliary verb a- 'to be' (see section 9.11.c)

13. хээр гараад: the indefinite case' is here used in place of the dative
14. бар хэлсэн нь: 'what the tiger said (was); as for what the tiger said:'
15. амь мултрах: 'to get away with one's life; to manage to save one's skin'
16. Хай хай горьгүй байгаа: 'Well now, that's hopeless'
17. минийх: 'mine'
18. хуга ойчжээ: 'fell (and broke it) to pieces'
19. юу идэхээ алд: 'And what would they eat! There won't be anything to eat!'
20. аль хэдийн: 'some time before'

LESSON 16

МУУ САНАА БИЕЭ ОТНО

Эрт урьд цагт нэг бяцхан хүү, их далайн дэргэд, дэрсээр овоохой барьж, гичгэнээр хоол хийж, усаар ундаа хийн суудаг байжээ. Тэр далайн тэртээ талд нэг ноён албат зарц ихтэй, адтуу мал олонтой жаргаж байдаг байжээ.

Мөн далайн дэргэд Менгэт уулын хярд нэг том агуайд таван зарцтай нэг лам суудаг байв гэнэ. Тэр лам нэг өдөр явж, баян ноёныд залагдан очив. Лам очоод, баян ноёны галыг тахиж өгөөд, баян ноёны бага авгайд аршаан гэж арай үхэхгүйгээр бага хор өгчээ. Ноёны бага авгай нойр хүрэв гээд хэд эвшээлгэн хэвтэж гэнэ. Ноён гайхаж, манай бага авгай, өдөр унтдаггүй билээ. Яасан сонин юм бэ? гээд ламд бараалхан хэлсэн нь:

“Олныг аврагч лам минь орж болгоож хайрла, бага хатан өдөр ер унтдаггүй юмсан, гэнэт сая унтав” гэв.

Лам босч ирээд, ноёныг дагуулан гарч хэлсэн нь:

“Би ч аргалж чадмаар байна. Миний хэлснийг та л гүйцэтгэвэл болно” гэв. Гэтэл ноён, та хэлж хайрла гэв.

Лам, ноёны их авгайг хуурч авах гэж хэлсэн нь:

“Ноён танд хэлье. Танай их хатан чинь тэр аяараа муламс болжээ.

Бага хатангaa идэх гэж байна.

Иймд их хатангaa авдарт хийж, алт, мөнгө, торгоор чигжээд, авдрын амыг хадаасаар хадаж, далайд хөвүүл” гэв. Ноён үнэмшиж их хатнаа авдарт хийж, алт, мөнгөөр чигжих, торго дурдангаар биеий нь ороон усанд урсгав. Лам ноёныхоос буцах гэргээ очоод шавьдаа хэлсэн нь:

“За, одоо усны захад очцогоо! Усан дотор нэг улаан авдартай юм урсаж ирнэ. Түүнийг уснаас гаргаад, миний агуайд тавь! Түүнийг онгойлгож болохгүй, нэг шулам дотор нь бий” гэв. Ламын хэлсэн ёсоор шавь нар нь усны захад очиж, улаан авдартай юмыг хүлээж суув.

Гэтэл усанд урсгасан хатан, негеө бяцхан хүүтэй дайралдав. Гичгэнэ ухаж суугаад, усан дотор авдар урсаж явахыг үзсэн негеө хүүхэд гүйн очиж, авдрыг татан гаргах ирээд, задалсанд алт, мөнгө, торго, дурдан гарч байгаад, гэнэт нэг гуа үзэсгэлэнт хүүхэн гарч ирэв.

Негеө хүүхэд асуусан нь:

“Та юун хүн ингэж авдартай урсаж явдаг юм бэ?” гэв. Авгайн хэлсэн нь: “Яах юу байх вэ? Ноён, лам хоёр намайг шулам гэж хэлээд, алах гэж байгаа юм.

Харин хүү минь хоёулаа амьдарья” гэв.

Хүү “еэз гялай, еэз гялай гэж хашгараад, тэгье” гэв. Гэтэл авгайн хэлсэн нь: “Чамд энэ авдар дотор хийгээд, урсгах юм байна уу” гэв.

Хүү “байхгүй” гэж дорой дуугаар хэлээд, дэрсэн овоохой руугаа хартал, нэг ярдаг шар жингэр зогеч байв. Гэтэл авгай түүнийг хараад, “тэр нохойг аваад ир” гэв. Хүү тэр нохойг барьж авчраад, негеө авдар дотор хийж, дэрс, евсөөр авдрыг чигжээд, хуучин янзаар нь хадаад усанд урсгав.

Үүнээс хойш бяцхан хүү хоёулаа болж амьдардаг байлаа. Гэтэл негеө авдартай жингэр урссаар ламын шавь нар дээр очив. Шавь нар эвтэй гэгчээр уснаас гаргаж аваад, ламын гэрт оруулав. Лам баярлаж, маш хөөрхөн авгайтай болсон гэж бодоод, шене онгойлгохоор шийдэж, шавь нартаа хэлсэн нь: “Та нар сайн хоол хийж, манайд оруул! Тэгээд эртхэн унт! Би шене авдрыг онгойлгож, тэр шулмыг хүн болгохыг бодно. Та нар орж тун ч болохгүй. Харин охин хүн орилоод л, хашгараад л байвал бүүр ч орж ирж болохгүй шүү” гэв.

Шавь нар хоол хийж, ламын агуйд оруулав. Гэтэл лам, шавь нараа дуудаж авчраад, дахин хэлсэн нь:

“Энэ шене хэн ч орилж, хэнийг ч дуудаж магадгүй, иймд хэн ч орж ирж болохгүй” гэв. Шавь нар, за гээд, ламдаа цөм мөргөцгөөж дуусаад, гадаа унтцагаав.

Лам нь негеө авдраа тавтай онгойлгож үзвэл, дэрс, евс гарч, алт мөнгөний хэлтэрхий ч гарсангүй; алт мөнгө гарахгүй байдаг ясан сонин юм бэ? гэж уур хилэн нь хөдөлж, модоор авдраа дэлстэл ардаг жингэр босон харайж, ламыг барьж авав.

Лам муухай хашгарч, шавь нараа дуудавч, шавь нар нь орж ирсэнгүй. Ярдаг жингэр ламын хоолойг тас казаж

бархирав. Өглөө, шавь нар ламын ундыг гадаа чанаад, оруулж өхөөр очсонд, ламы нь ярдаг хингэр барьчихаад хэвтэж байна. Үүнийг үзсэн шавь нар ламын хүүрийг агууд нь түгжээд "муу санаа биеэ отно гэдэг болжээ. Биднийг дуудсан бол энэ нохойгоос бид салгаж өхгүй юу!" гэж ярилцаад, ламын шавь нар тарж тус тусдаа амар сайн амьдардаг болжээ.

Notes

1. Мүү санаа биеэ отно: a Mongolian proverb: 'If you dig a hole for others, you may fall into it yourself' (lit.: A bad intention ambushes oneself.)
2. бага авгай: 'the junior wife' (in a polygamous household)
3. нойр хүр-: 'to get sleepy'
4. хэвтэж гэнэ: '... lay down, they say'; this is not the imperfect converb, but the short form of the finite -хээ suffix (see section 8.9.a)
5. ...гүйцэтгэвэл болно: 'If you carry out what I say, it will work (will turn out all right)
6. аяаараа: note the reflexive suffix
7. ноёныхоос: 'from the noyon's'
8. хатангaa/хатнаа: within the same paragraph the word is declined both with and without the hidden 'g'; it is most commonly declined without a hidden g
9. овоохой руугаа: note that the reflexive suffix is added to the postposition
10. хоёулаа болж,: 'started living as a couple'
11. эвтэй гэгчээр: 'with great concord; with the greatest convenience'
12. ...хэтэрхий ч гарсангүй: 'not even a scrap ... came forth'

LESSON 17

ЧӨТГӨР СҮНДАЛСАН НЬ

Энэ явдал дөрвөн жилийн өмнө болсон билээ. Сайхан тунгалаг сартай нэг шенө, Боржинтын зүүн энгэр дээр буусан гурван гэрийн баруун хойноос цагаан тоос татуулан довтолгож яваа нэг хүнийг харвал юманд хөөгдсөн юм шиг байлаа. Хот айлын хүмүүс гаднаа гарч тэр хүнийг гайхан харж байтал, сумын төв орохоор явсан өвгөн Луузан мориныхоо хар зурдаар ирээд “та минь энэ айхтрыг...” гээд ухаа алдав. Хүү Тэмэр сандран очиж мориноос буулгаж авахад номхон хүрэн морь пь багтарчих шахаад амьсгаа нь багтаж ядан гэдэс нь бүлхэлзэн хөлс нь дусалж байв.

* * *

Луузан өвгөн, дэнгийн сүүмэлзэн бүдэг гэрэлд гэрийнхээ хоймрын хар хялгасан зээгтэй ширмэл ширдэг дээр суугаад айсан сандарснаа хэлж ядан;

--Наашаа явж байтал үдшийн бүрэг бараг болов. Нэг мэдсэн чинь Мааньтын тойромд орчихлоо. Энд тэндгүй л үхсэн хүний яс гялайж цайгаад ар өвөрт юм сүр сар, хүүе хааяг гэх шиг болоод бүх бие зарас гээд л явчихлаа. Би маань мэгзэмээ уншаад, юу ч болсон бушуухан явъя гэж бодоод мориндоо ташuur өгөн давхитал миний хойгуур нэг юм сэв гээд сундалчихтайгаа зэрэг л задгай энгэр рүү минь салхи ороод хөвхөлзөж байсан тэрлэгний минь захнаас шүүрэн авч мушкиад хойш нь хөдөлгөлгүй дарчихлаа. Бүр сүүлдээ араас минь тас тэвэрчихээд эрүүгээрээ нуруун дээрээс үрээд ямар аюултай юм болсон гэж санана... Би ер худал хэлэхгүй, яах аргагүй чөтгөр сундалсан юм даа. Мааньтын тойрмыг чөтгөртэй гэдэг чинь үнэн юм байна шүү гэхэд:

--Ааваа таны тэрлэгний чинь захнаас, гаизаганд чинь байсан чөдрийн хойт сумны нь чагт тээглэсэн байсан шүү дээ. Тэхээр таны ард сундалдаг чөтгөр чинь энэ л байх нь дээ! гэж гурамсан эрчтэй чөдөр харуулахад, Луузангийн яриаг чагнаж суусан багийн сувилагч, хот айлын нь хүмүүс, тохуурхаж айхад аргал бендөлзөнө гэж уул нь ч гайгүй л сайн таньдаг чөтгөр сэнж дээ гэж ёжирхуугаар инээлдэв.

(Н. Гомбодоо)

Notes:

1. баруун хойноос: 'from the northwest'
2. гаднаа: note the reflexive suffix
3. сумын... явсан: 'who had left to go to the somon center'; note the indefinite case used in place of the dative suffix
4. хар хурдаар: 'at full speed; head over heels' (lit.: 'by black speed')
5. та минь: 'you of mine'; this manner of modifying one pronoun with another is quite common in Mongolian: 'I of yours', 'we of yours', 'they of ours', etc.
6. айхтрыг: colloquial pronunciation of айхавтар + accusative suffix
7. наашаа: note the reflexive suffix
8. үдшийн бүрэг бараг: 'evening dusk'
9. сүр cap, хүүе хаая гэх: 'to rustle and to screech'; there are innumerable onomatopoeic expressions in Mongolian for sounds, types of motion, etc.
10. зарас гэх: 'to send off suddenly'
11. юу ч болсон: 'no matter what; whatever happened'
12. миний хойгуур: 'in the region behind me; behind me somewhere'
13. сэв гээд: 'having sprung up easily'
14. сундалчих: intensive form of сундлах

15. тэрлэгний/захнаас: these words are here declined as if they had a fleeting -n in their stems, which is not the case (see section 0. 10)

16. хөдөлгөлгүй: 'without causing to move; without moving'

17. дарчих-: intensive form of дарах

18. тас тэвэрчихээд: 'having locked (me) in a firm embrace'

19. тэхээр: 'rather than being thus (i.e. like you thought it was)'; the suffix -aap sometimes has a comparative meaning where one action is preferred to another 'rather than..., instead of...'. The literal meaning here is 'Instead of doing thus, rather (it was such and such)'.

20. Энэ л байх нь дээ: 'is probably this one; this must be it'

LESSON 18

ЗАХЫН ГАНЦ МОДНЫ УЧИР

Гудамжны хоёр захын явган зам дээгүүр зорчигчид олон тул хааш хэрэг алхаж болохгүй байв. Том хувин бялхам сүү барьж, хүүхэд хөтөлсөн авгай богинохон алхалж явна.

Тохиолдогчид төд төд зам тавин өгч, энэ авгай хэнээс ч илүү, сааталгүй урагшилж байв. Гэтэл урдаас нь хол хол алхаж зорчигчдын дундуур хага зүссэн, юунд ч хэнд ч торж saatdagguй нэг хүн гараад ирлээ.

Тэр хүн авгайд зам тавих өх шинжгүй, шууд тэмүүлэн айсүй. Авгай сандарч, хувинтай сүүгээ баруун гартаа сэлгэн барьж, зам зайлж өх хооронд өнөөх хүн дээгүүр харж, авгайг мөрөөрөө шахан ирэв.

Авгай бүр тэвдэж, бушуухан зайд тавих гэж ухасхийгээд, довжооны ирмэгийг халт гишгэж, сүүгээ нэлс хийтэл асгаж орхив.

Авгай асгарсан сүүнээс духандаа түрхэж, харамссан нүдээр эргэж үзэв. Гэтэл өнөөх гай болсон хүн ахиг ч угүй, данагар данагар алхсаар далд орж явлаа.

Хоосон хувингаа барьж, асгарсан сүүгээ эргэн эргэн харж явагч авгай:

Данагар данагар алхаатай

Дал мөрөөр дүрсэн отготой... гэж феодалын үеийн нэг дуунд гардаг юм. Урьд цагт феодалууд ард олныг хүндэтгэдэггүй, хорхой шавьжийн төдий ч тоомсорлон үзэхгүй, харин дэргэдүүр нь данагар данагар алхаж дайрчихад холгүй омгорхон явдаг гэм бол феодалын суртал юм шүү гэж хүүхдээ сурган хэлж байв.

Хонх дуугарав. Кино үзэх танхимд үзэгчид дугаарлан орж эхэллээ. Гэтэл өнөөх авгайн сүүг асгуулж, гай болсон хүн, дугаарын эх рүү дайрч байх нь харагдас. Аятайхан дугаарлан зогссон хүмүүс, бие биеэ шахан түлхэлдэж, бид хэдэн хүн дугаараас бүлтэрч гарав. Биднийг дугаарын сүүлд орж зогсох үед, өнөөх “дайчин эр” бусдыг түлхэн нудран зүтгэсээр, үзэх танхим руу тэмүүлэн орох нь харагдас.

Гэрэл унтарч, кино эхлэх арай болоогүй байв. Миний урьдахь сандал дээр суусан хүн, уншиж байсан сонингго сандал дээрээ орхиж, түр явах хооронд өнөөх “дайчин” ирж, сонингий нь авч хаячхаад, сандлыг эзэлчихэв. Үхэн хатан яарч, сандарч орж ирсэн хүн маань өнөө болтол суух газар олоогүй, юу эрж явсан хэрэг билээ. Юунд тэгж яарсан юм бол гэж бодож суутал, түрүүчийн хүн ирж, шал дээр хэвтсэн сонингго олж аваад, ондоо сандал тийш очив.

Кино гарч эхлэв. Өнөөх “дайчин” том малгайгаа духан дээрээ дунхайтал тавьж суугаад, байгаад л гараа сарвалзуулан суниан, байсхийгээд л өрөөсен хөлөө сандал дээр авч улам овойн суугаад, экранг халхлах тул ары нь хүмүүс киног дутуу хагас үзэж байв. Гай болж энэ “дайчин эр” яг урьд минь эгц тохиолдон суусан тул миний нүд экранаас бүр тусгаарлагдаж, кинони зөвхөн дуугий нь сонсож суув. Гэтэл мань “дайчин”-ны хажуу дахь хоёр хүүхэн” “хөл дэгээдээд байна, наад хүн, цаад хүн” гэж шивэр авир ярилцаж, мань хүн ч гэсэн хоёр хүүхэнд:

--За энэ хүн чинь сүүлдээ, тэр түрүүний хар сахалтай хүнд алагддаг юм. За, за, энэ хоёр чинь ингэсхийж байгаад үнсэлцидэг юм гэж киног урьдчилан тайлбарлаж, чанга ярих тул сүүлдээ кинони дуу нь ч ойлгогдохoo болив.

Нэг мэдсэн, мань хүн шагширтал гасалж байна. Экран дээр тийм их гасалмаар явдал болов уу гэтэл бусад хүмүүс чив чимээгүй үзцэгээх байна. Мань “дайчин” юунд гаслав? Өнөөх авгайн сүүг асгуулчихсанаа санаад гасалж байгаа юм уу? эсхүл нохой дагуулж ирсэн юм бол уу? гэж санаж суутал кино дуусч гэрэл асав.

Хүмүүс журамтайгаар цувран гарч эхэллээ. Гэтэл хүмүүсийн дунд хүчтэй түлхэлт үүсч, нэг зуур шахалдаж эхэлснийг үзэхэд мань “дайчин” л үүнийг үүсгэжээ.

“Дайчин” энэ танхимд орохдоо амь тавъж, хичнээн яарч, сандарч орсон билээ! Үүгээрээ бол гараждаа яарахгүй баймаар, гэтэл тэгсэнгүй, тэнд удаан байхаас ухаа алдталаа айсан юм шиг, хүмүүсийг дайрч, ёврч довтолсоор хамгийн түрүүнд гарч байх нь харагдav.

Киноогоос тарсан хүмүүс зүг бүр тийшээ явцгааж, гудамжинд хөл татрав. Кино үзэх танхимаас хамгийн түрүүнд гарсан мань “дайчин” киноны үүдэнд хамгийн сүүлд хоцорч, ташаа тулаан зогсохи нь үзэхэд ойн захын ганц мод санаанд оров. Багадаа пионерын лагерьт гарч, ойд экскурсээр явж байсан нэг үед, ойн захын ганц модны учрыг багш минь, бидэнд хэлж өгч байсан нэг явдал санагдav.

--Чигжүү ой доторхь модод гуалаг, мөчрүүд нь жигдээн, цэвэрхэн ургаж, биесээ халхлахгүйн тул шилмүүс бүр, навч бүр нарны гэрлийг саадгүй үзнэ. Харин ойн захын онцгой мод бол хажуугаасаа шахагдах хавчигдах зүйлгүй болоод аравгар саравгар, тахир мухир ургаж үзэмж муутай харагддаг шүү дээ.

Олны хөлийн газар, боловсон ёс дэглэмийг хайхардаггүй, хааш яаш явдаг хүн, ойн захын мод шиг үзэмжгүй харагддагаар ч барахгүй, бусдынхаа челеет аж байдалд хортой байдаг юм байна.

(Л. Бадарч)

Notes:

1. хааш хэрэг: (*here:*) 'in any direction; at random'
2. богинохон: 'walking with rather short steps'
3. төд төд: 'everyone, as they came'
4. хол хол алхалж: 'walking with long strides'
5. хага зүссэн: 'who cut through the middle of the pedestrians'
6. довжооны...: 'platform' here refers, of course, to the 'platform' of the sidewalk.
7. бие биеэ: 'each other, one another'

8. Биднийг...зогсох үед: note the subject in accusative case; see section 15. 1.
9. Кино...боловгүй байв: 'The movie was just about to begin'
10. байсхийгээд: 'having suddenly stopped (that)'
11. ингэсхийж байгаад: 'having quickly done like this'; see section 14. 7.
12. нэг мэдсэн: (freely:) 'Before you know it ...'; 'suddenly'
13. чив чимээгүй: 'without a murmur, completely quiet'; see section 13. 3.
14. асгуулчих-: intensive form of асгуулах
15. нэг зуур: 'for a moment'
16. зсхүл: the suffix -хул (-хүл) is rarely used; it carries the same meaning as the conditional suffix -вал (see section 9. 1)
17. ...юм бол уу: 'Could it be that he... ?'
18. киногоос: The Mongols pronounce the final 'o' of КИНО as a long vowel (but the word keeps its Russian spelling) — hence the form of the suffix.
19. санаанд оров: 'came to mind'
20. багадаа: 'in my childhood'

LESSON 19

ХҮРЭН ТОРГОН ДЭЭЛТ ХҮҮХЭН

Халхад хамгийн сайн эр гэж алдаршсан нэг сайн хулгайч байжээ. Тэр хулгайч, ханилах сайн эр, унах сайн морь эрж сураглаж байжээ. Гэтэл тэргээ баруун урд зүгт, Хүдэрийн чулуутаар нутагтай, хүрэн тортон дээлт хүүхэн гэж нэг сайн хулгайч хүүхэн байдаг гэж дуулаад, тэр хүүхэнтэй нийлж хулгай хийхээр шийдээд хүн амьтнаас асуух сурагласаар байж нэг юм очжээ. Тэгсэн чинь жижигхэн бор гэрт нэг эмгэн сууж байна гэнэ. Сайн эр, тэр эмгэнтэй мэнд усаа мэдэлцээд танайх Хүдэрийн чулуутаар нутагтай, хүрэн тортон дээлт хүүхнийх мөн үү? гэж асуухжээ. Эмгэн: мөн. Хүү минь юу гэж яваа вэ? гэж хариу асуухжээ.

Би танай хүүхэнтэй нийлж хулгай хийхээр ирлээ гэж сайн эр хэлжээ.

- Аа тийм үү. За хүү минь, манай хүүхний уудаг цай, иддэг хоол энэ гэж, үхрийн өрөөл мах, хүрэл тогоо дүүрэн цай уудалж өгчээ. Хар хүн цай хоолы нь идэх баралгүй буцаагаад өгчээ. Эмгэн: Юнд нэрэлхээд байгаа юм бэ? Ийм бага иддэг бол хулгай хийж чадах юм уу? Хүү минь одоо унтаж амар даа гээд ор засч өгчээ. Хар хүн унтаж байгаа юм шиг хэвтэж байтал, бүрээ бишгүүр дугараад байхлаар нь: Танай энд юн хурал хурдаг юм бэ? гэж асуухжээ.

- Манай энд хурал ном хурдаг газар байхгүй. Манай хүүхэн ирж явна. Тэгээд ийм дуу гарч байгаа юм гэж эмгэн хэлжээ. Удсангүй гадаа нь морьтой хүн ирж, нэг юм пид хийтэл хаячхаад орж ирэнгүүт: Ээжээ энэ унтаж байгаа хэн бэ? гэж асуухжээ. Эх нь: Охин минь чамтай ханилахаар ирсэн хүн гэжээ. Хүүхэн тэр хүнийг сэрээж босгоод амар мэндээ мэдэлцэж: Би нэг юм авчираад гадаа орхичихсон. Чи түүнийг оруулж ирээд өвч. Чанаж идцэгзэе гэхэд хар хүн гарсан чинь нэг шар алаад, дөрвөн хөлий нь боож, тохойдоо өлгөж ирээд хаячихсан байжээ. Хар хүн: Би шарыг яж ганцаараа оруулах вэ? гэхэд хүүхэн ганцаараа

оруулж, хонь шиг өвчихээд, өрөөл махы нь гэдэс доторгой нь чанаад тэн хагасы нь хар хүнд өгөөд үлдсэн хагасы нь өөрөө идчихжээ. Гэтэл хар хүн хоёрхон хавирга мөлжээд бусды нь барагүй үлдээж гэнэ.

Та холоос ирсэн болохоор их ядарсан байлгүй дээ. Хоёр гурав хоноод мордоно. Тэр болтол амар гэж хүүхэн тэр хар хүнд хэлжээ.

Хүүхэн нэг өдөр: За маргааш явна гэжээ. Тэгээд тэр хоёр маргааш нь гурав гурван морьтой гараад гурван өдөр, гурван шөне нойргүй явжээ. Хар хүн маш их ядарч, арай чарай чирэгдээд явдаг болжээ. Гэтэл нэг өдөр уулан дээр гараад: Тэртээ баруун урд юу харагдаж байна гэж хүүхний асуухад хар хүн: Олон адуу харагдаж байна гэжээ. Хүүхэн, юм харахдаа овоо юм байна гэж бодоод цааш явж, нэг чулууны дэргэд буугаад том чулуу ховхлоход дор нь халуун цай, хоол бэлэн байна гэнэ. Тэр хоол, цайгаас идэж, уугаад: Одоо жаахан амрах уу? гэж хар хүн хэлэхэд хүүхэн: Үгүй, яалаа гэж амрах вэ? Тэр олон адуунаас тасдаж аваад хееене. Энд хоёр айхтар азрага байдаг юм. Бид хоёрыг ойртоод очижоор давхиад ирнэ. Тэхлээр нь би тэр хоёрыг бариад авмагц, чи тэр самбаанд бушуухан зайлсаарай гэжээ. Тэгээд адуунд сийрттол нээрээ ч хоёр азрага давхиад иржээ. Хүүхэн буун харайж, ганзагатай сураа аваад хоёр азрагатай ноцолдож эхэлжээ. Хар хүн тэр хооронд нь хоёр зуугаад адуу тасдаж аваад хөөжээ. Хар хүнийг нилээн хол очсон хойна хүүхэн хоёр азрагы нь тавиад иржээ. Хоёулаа адуугаа хөөсөөр яваад бүр хол явчихжээ. Гэтэл нэг шарга даага хойноос нь дагаад ирж гэнэ.

- Та холоос ирсэн хүн байна, энэ адууг ав. Энэ шарга даагыг аваачаад дервэн хөлөөс нь чөдөр битгий салгаарай. Би чамтай нийлж хулгай хийхгүй. Чи бүтэл муутай хүн юм. Үүнээс хойш чи миний дууг нэг сонсох байх, барааг нэг харах байх гээд явчихжээ. Хар хүн олон адуу туусаар гэртээ харьжээ. Тэгээд өнөөх шарга даагыг үргэлж унаж, чөдерлөөд байжээ. Шарга даага нь том хөгшин морь болж гэнэ. Хар хүн нэг өдөр: Энэ хөөрхий даага байхдаа ирсэн юм. Одоо хөгшин болж, хөлий нь амрааж үзье гээд шарга морио адуунд сул тавьжээ. Гэтэл шарга морь нь тавингуут баруун урагшаа зугтаажээ. Хойноос нь хоёр сайн мориор сэлж хөөгөөд гүйцэлгүй явсаар нэг худаг дээр очтол, шарга морь худгаас ус уугаад зогсжээ. Хар хүн, худгаас ус

татаж байсан хүнд: Наад шарга морио бариад өгөөч гэжээ. Гэтэл худгийн хойт захад чулуу дэрлээд унтах байсан ухаа шар дээлтэй лам босч ирээд: Наад хүнээ өөрий нь бариад ав. Урьд манайх энэ шарга морийг даагаа байхад нь сүрэг адуутай хамт алдсан юм. Хулгайч нь наадах чинь мэн гээд тэр хар хүнийг барьж аваад, үхрийн ширэнд боож, өндөр модноос дүүжилжээ. Хар хүн, ширээр ширлүүлж, модонд өлгөгдөөд хэзээ үхэхээ бодож, хөдөлж чадахгүй тарчилж байтал, дор нь нэг хүний дуу гарч: Хар хүн та амьд байна уу? Таныг ширлэсэн хүн би байна. Одоо нар жаргах гэж байна. Гэгээ тасарч байгаа байх гэх үеэр хөлөө сайн хийгээрэй. Яг хөлийн чинь дор өлөн гэдсээр оёсон, бусад газар нь ширээр үдсэн шүү. Толгойн чинь дээд талд шар тос, хурц тонгорго хоёр бий. Шар тосноос идээрэй. Тэгээд гэгээ тасрахаар хөлөө жийж, өлөн гэдсэн үдээсийг зад татан гарч баруун урд руу ороорой. Тэнд олон айл байгаа. Хамгийн баруун урд талын том цагаан гэрийн баруун урд талд ламын илүү өргөө бий. Тэр гэрийн баруун хаяанд эмээл хазаар, дээл хувцсы чинь тавчихна. Морий чинь, баруун урд талын тэргэний тэнд, олон морины хамгийн баруун захад нь тушаад орхичхено. Чи хувцсаа өмсөөд, морин дээрээ мордсон хойноо, баруун урд талын том цагаан гэрийн тогтгыг хутгаараа яраад, өнөөх чулуу дэрлээд хэвтэх байсан ламд ингэж хэлээрэй: Надаар туг мялааж чадах уу? Одоо мялаах цаг боллоо! Сэргээч, босооч! гээрэй. Тэгээд зугтгаачих. Би одоо явлаа гээд явчижээ. Хар хүн үнэн худлыг мэдэхгүй дэмий л толгой дээгүүрээ тэмтрээд Үзвэл тонгорго, тос хоёр байжээ. Тосноос нь идэх, баахан сууж байгаад одоо л гэгээ тасарч байгаа байх гэхийн алдад хөлөө жийсэн нь өлөн гэдсэн үдээс зад татаж, үхрийн ширнээс хар хүн сугаран гарчээ.

Хар хүн явсаар баруун урд уруу оржээ. Гэтэл олон айл байна гэнэ. Хамгийн баруун урд талын айлын тэргэний тэнд олон морь нь байна гэнэ. Нэг том гэрийн баруун талд жижиг өргөө байна гэнэ. Сэмхэн ортол хатавчинд нь хувцас, эмээл хазаар нь байжээ. Хар хүн хувцсаа өмсч, эмээл хазаараа авч гаран морио эмээллэх мордоод баруун урд талын том цагаан гэрийн үүдэнд очиж, хурц тонгоргоор тогты нь яраад: Хөөе лам aa! Чи надаар туг мялааж чадах уу? Одоо мялаах цаг боллоо. Сэргээч, босооч! гэж хашгираад зугтаажээ. Лам яж ч чадсангүй хоцорч, хар хүн нутагтаяа хариад амар сайхан жаргажээ. Харин өнөө хүрэн торгон

дээлтэй хүүхний дууг ч дуулсангүй, барааг ч харсангүй.
Тэр хүүхэн, лам ноёдын юмыг хулгай хийж, ядуу харц ардыг
тэтгэн, халхын хамаг сайн эрсийн хав бахыг төрүүлж явжээ.

Notes:

1. баруун урд: 'south east'
2. Хүдэрийн чулуутаар: a place name
3. хар хүн: 'layman, commoner'; now also 'citizen'
4. удсангүй: 'before long, before much time had passed'
5. пид хийтэл: 'so that it went "thump"'; lit: 'until it did "thump"'
6. идцэгээе: 'let us eat together!' (of several persons)
7. ганцаараа: 'all alone by myself'
8. өвччих(өөд): intensive form of өвчих
9. идчих(жээ): intensive form of идэх
10. тэр болтол: 'until then'
11. гурав гурван морьтой: 'each with three horses'
12. тэхлээр нь: 'then, thereupon'
13. хоёр зуугаад: 'about two hundred'
14. өгөөч: second person singular imperative (see section 10. 4)
15. үеэр: 'during the period when...'
16. шар тос: 'ghee; boiled, melted butter'
17. тосноос идээрэй: 'eat some of the butter'; the ablative is here used in a partitive sense.
18. тавчих(на): intensive form of тавих
19. тэргэний тэнд: 'by the wagon'; when тэнд is preceded by a genitive it is translated as: 'by, at'
20. надаар...: 'by me, with me'; i.e., 'are you able to sacrifice me to the standard?'

21. яж ч чадсангүй: 'being unable to do anything (about it)'

22. (төрүүлж) явхээ: note that the verb явах in many cases has a much wider meaning than simply 'to go'; here it rather signifies the whole motion of life. In colloquial English it would either not be translated or it would have to be circumlocuted.

LESSON 20

НИЙСЛЭЛ ХҮРЭЭНИЙ НЭРИЙН ТУХАЙ

Улаанбаатар хот анх үүссэн цагаас эхлэн нэг тогтмол нэртэй байсангүй. Анх хутагтын “Өргөө” гэж үүсч цаашдаа “Их Хүрээ”, “Нийслэл Хүрээ”, “Улаанбаатар хот” гэж нэрлэгдэх болжээ.

Гэвч, дэлхий дахини судар бичиг, монголчуудын аман ярианд олон янзаар нэрлэгдэх байжээ. Жишээ нь: Монгол, манж, хятадын судар бичигт “Даа Хүрээ”, “Их Хүрээ”, “Хутагтын Хүрээ” мөн “Ку-Лунь” гэж бичигдсэн ба монголчуудын дунд “Богдын Хүрээ” гэж алдаршжээ. Түүдийн судар бичигт “Рибогэжиганданшадублин”, бас заримдаа “Чонмо” гэдэг. Орос, европын судар бичигт “Урга” гэж нэршжээ.

Тус хотын нэр тийнхүү олон янзаар нэрлэгдэх болсон явдал, түүний хөгжлийн түүхтэй шууд холбоотой юм. Монголчууд, эрт дээр үеэс ямар нэгэн феодалын нутаглан суух орон байрыг тийм хааны өргөө, ийм ноёны өргөө гэх мэтээр нэрлэх иржээ. Тус хот анх үүсэхдээ Халхын Түшээт хаан Гомбодоржийн хүү Өндөр гэгээн гэж алдаршсан Занабазарын өргөө гэж үүссэн учир тийнхүү өргөө гэж нэрлэгдсэн болно. Тэр үед монголчуудтай харилцаж байсан оросууд өргөө гэсэн үгийг Урга гэж хазгай дуудаад тэр нь орос, европын судар бичигт тус хотын нэр болж одоо хүртэл алдаршжээ. Юунд тийнхүү нэрлэх болсон тухай орос, баруун европын эрдэмтнүүд олон янзаар тайлбарлахыг оролджээ. Урга гэдэг бол (морь уургалдаг) уурга, (ургах, ургаа мод) ургаа гэдэг үгээс гарсан юм гэх мэт элдвээр тайлбарладаг байна. Гэтэл, тэр тайлбарууд таамагласан зүйлүүд тул үнэн байдалд тохигохгүй юм. Харин Оросын зарим монголч эрдэмтэн, мөн Монголын эрдэмтдээс хутагтын өргөеннд ирсэн орос, бусад გадаадын хүн өргөө гэсэн үгийг буруу хазгай дуудсанаас Урга гэж нэрлэх болжээ гэсэн тайлбар оновчтой юм. “Орос хэлэнд Ө үгүй

учраас Ө-г У-гийн дуудлагаар дуудаж - Хутуктийская Урга гэж нэрлэгдэх болжээ”. 17-дугаар зууны эцэс, 18-дугаар зууны эхээр Монгол нутгаар явсан оросын элч, худалдааны хүмүүс тэр үед хутагтын өргөөг Урга гэж нэрлэн байсан нь олонтоо тохиолдох юм.

1730-аад онд явж өнгөрсөн оросын элч нар бичихдээ “Урга бол Сэлэнгэ хот (монголчууд Сэлэнгийн Цагаан байшин гэж нэрлэдэг байсан)-оос 250 мод газар хэдэн зуун гэр тал нутагт бий” гэж бичжээ. Гэтэл, 1666 онд үүссэн Сэлэнгийн Цагаан байшин гэдгээс Хиагт хүртэл 105 мод зайдтай, Хиагтаас өргөө 145 мод орчим байх гэж бодоход тэр үед өргөө Ийвэн голд байсантай тохирч байгаагаар үзэхэд тэр нь Хутагтын өргөө мөн юм.

Мөн “Орхон - Ийвэн голын бэлчирт урьдахь Хутагтын орон Урга байсан...” гэж 1763 онд Миллер бичсэн байдаг. Тэдгээр баримт нь Хутагтын өргөөг Урга гэж байсан бас нэг баримт. Тийм баримт олон байна. Хүрээ гэж нэрлэх болсон үгийг тайлбарлахдаа хашаа, хороо, бас сүм дуган гэсэн юм гэж тайлбарладаг байна. Гэтэл, энэ нь хүрээ гэсний шууд тодорхой тайлбар биш.

Монгол нутагт шарын шашин өргөн дэлгэрч, сүм хийд олноор бий болж, түүнийг даган, лам нар, харчууд, худалдаачид суурьшин нутаглах газрыг монголчууд хүрээс гэж нэрлэдэг боловч тэрнийг хашаа, хороо барьсан, сүм хийд бий болсноос тэгж нэрлэдэг болсон хэрэг биш юм. Харин хүрээ гэдэг үг эрт дээр үеэс гаралтай. Монголчууд хэдэн зуун өрхөөр тойрон буудалладаг байсныг хүрээ гэдэг байжээ.

“Олон гэр цагариг мэт тойрон талд буудалласныг хүрээ гэдэг байсан юм...”, “Эрт үед ямар нэгэн аймаг аль нэгэн газар цагариг мэт тойрон буудаллаж, түүний дунд ахлагчийн гэр байдаг байсан, түүнийг хүрээ гэж нэрлэж байжээ” гэж 13-дугаар зууны Үед түүхч Рашид-эд-Дин бичжээ. Түүнийг оросын монголч эрдэмтэн Владимирцов мөн зөвшөөрөн бичжээ.

Монголд үүсэн байгуулагдсан хийд мөн тэр хуучин хурмыг дагаж ихэнхдээ гол төвд нь гол их дуган орнууд бий болж, түүнийг тойрон бусад дуган сүм, лам нарын байр барьдаг байснаас хүрээ хийд голдуу дугуй хэлбэртэй байжээ. Тийм учраас хүрээ гэдэг үг томхон хийдийн нэр болжээ. Хүрээ ингэж бий болсны дотор 18-дугаар зууны эхнээс Богдын өргөө Халхын доторхи шашны

төв болж түүнийг бусдаас онцгойлон Их Хүрээ гэж нэрлэх болжээ.

Түвшдэд алдаршсан нэр нь өргөөнд байгуулсан гол дуган “Рибогэжиганданшадублин” гэж нэрлэснээр гарсан ба тэр нэр олонд ихэд алдаршсангүй. “Чонмо” гэсэн нь Их Хүрээ гэсэн түвд үг. “Ку-Луинь” гэсэн нь хүрээ гэдэг үгийг мөн хятадууд хазгай дуудсанаас гарчээ.

Монголд автономит засаг тогтсоны дараа Их Хүрээг Монгол улсын нийслэл болгон зарлаж “Нийслэл Хүрээ” гэж нэрлэжээ.

Ардын хувьсгал ялсны дараа, Улсын анхдугаар Их хурлаас Нийслэл Хүрээг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын нийслэл хот болгон зарлаж “Улаанбаатар хот” гэж нэрлэжээ. Тэр үеэс тус хот нь Бүгд Найрамдах Монгол Ард Улсын улс төр, эдийн засаг, соёлын төв болж, нийт даяар Улаанбаатар гэж алдаршжээ.

Notes:

1. цаашдаа: ‘later on’
2. олон янзаар: ‘in many ways’
3. Рибогэжиганданшадублин: This was the official name of the most important monastery in Urga. Its Tibetan form is: *ri bo dge rgyas dga' ldan bshad sgrub gling*
4. эрт дээр үеэс: ‘from antiquity; from earliest times’
5. гэх мэтээр: = гэх мэт
6. элдвээр ‘variously’
7. эрдэмтдээс: see section 4. 2. d; this is a plural of эрдэмтэн which in itself is structurally a plural
8. учраас: ‘because; for the reason that’
9. 1730-аад онд: ‘in the 1730's'
10. хот (...)-оос: this division between the stem and suffix when a parenthesis, a title, etc., is inserted is common in Mongolian
11. ...байгаагаар: ‘when one looks at it as being equivalent to ...’
12. олноор: ‘in profusion; greatly, numerously’

13. тэрнийг: = түүнийг

14. барьдаг байснаас: 'because its being built..., from its being built... '

15. тийм учраас: 'therefore'

16. сий болсны дотор: 'during its becoming thus'

17. Их хурлаас: see section 4. 2. d

LESSON 21

СУУДАГ ГҮЙДЭГ ХОЁР

Нэг байгууллагын нэг тасалгаанд хоёр ажилтан сууж ажилладаг байв. Нэг нь ня-бо, нөгөө нь байцаагч юмсанжээ. Байцаагчийг Суурь гэнэ. Суурьтай эр байж дээ. Ня-боог Шуурай гэнэ. Шуурхай эр байж.

Энэ хоёр өглөө ажилдаа зэрэг ирж үзээгүй юм байж. Тийм ч учраас өглөө, хэн сүүлдэж ирсэн нь түрүүлж ирсэндээ олон дахин бөхийн мэндэлдэг заншилтай.

Тэр нэг өглөө, Суурь есөн цагтай уралдаад амьсгаадсаар ажилдаа ирээд, бүртгэгчид очиж:

- Суурь, Шуурай хоёр яг есөн цагт ирлээ - гэхэд, цааснаас нүдээс салгадаггүй бүртгэгч, Суурь 9-00, Шуурай 9-00 гэж бүртгэв. Ес гучийн үед Шуурай гуай шуурхайлан ирээд, олон дахин бөхөлзэн “Амрыг эрье” гэж Суурьтай мэндэлсэн нь “найзыгаа бүртгүүлж амжаа биз” гэсэн ёгт санаа билээ. “Амрыг эрье” гэж Суурийн хариулсан нь “найз минь, санаа амар!” гэсэн утгатай байжээ.

Шуурай үзэг, харандаа, баллуур, шугамнаас аваад том сампин, тооны машин, хавтастай данс бичиг гаргаж ширээн дээрээ өрсөн нь байдал маш сүртэй. Суурь ширээн дээрээ олон юм дэлгэх дургүй, харин үнсний сав хоёр гурвыг зэрэгцүүлж тавиад хайрцаг палирос нээж бэлтгэв. Суурийг хөдөлж ядаж байхын хооронд Шуурай найман тасалгааг нааш цааш нь сүлжээд, арван сонин юм сонсож ирлээ. За, юу юу мэдээ вэ гэтэл, Найдангийн тушаал дэвших гэж байгааг мэдэж, Дамбын найр маргааш болохыг мэдэж, дартын машин хээр суусныг мэдэж, цалингийн цэс бэлхэн болсныг мэдэж, Цамбын гэргий жирэмсэн болсныг мэдэж дээ.

Энэ мэдээгээ Суурьдаа хэлээд Шуурай гуай “холдоогүй” гэдэг нэртэй аяндаа мордлоо. Хоёр дэлгүүр дамжин, нэг артельд очиж малгай захиалаад, цагчингаар ороод зурагчингаар дамжаад үсчинд хүрэхээр гүйж гарчээ. Энэ хооронд Суурь гуай сууринаасаа ховхролгүй албан мэдээ

шаардах арваад удаа утасдаад, ам заавар өх гэж тав дахин утасдаад, арваад папирос баагиулж албан тасалгаагаа униартуулж байжээ.

Гонгор гэдэг хүн гаднаас ирээд ия-бо Шуурайг сурагласанд “Одоохондоо алга, ороод ирнэ удахгүй” гэж Суурь хариуллаа. Гонгор гучин минут хүлээгээд “За, яадаг билээ хойтихи ажил хэцүүдлээ” гэхэд Суурь “гадуур ажилд явчив бололтой” гэлээ.

Гонгорыг гарсан дор, Шуурай шуугин орж ирээд, хойт артельд костюм захивал хямд юм, урд дэлгүүрт усны гутал элбэг байна. Баруун мухлагт барааны саван гарч байна. Зүүн гуанзанд зүгээр пиво худалдах байна - гэж ярьснаа бас дахин шурд хийгээд гарч одов.

Гонгор орж ирээд, бас л ирээгүй ю! гэхэд Суурь “Ирсэн, ирсэн!” гэж тамхинхаяа утаанд хахаж цацан хэллээ. “Тэгээд хаана байна” гэхэд нь “холдоогүй” гэлээ. Гонгор хорин минут хүлээгээд “бас ирэхээ ёнгөрөх шив” гэхэд, Суурь сууринаасаа ховхорч, “би олоод ирье” гэлээ. Гонгор ганцаараа үлдээд хүлээж гучин минут боллоо. Шуурай ч алга, Суурь ч алга. Гонгор гонсойгоод буцлаа.

Хоёр “аврага” хоёр цагт kontortoo ирлээ. Суурь, үдээс өмнө үүрэгт албан ажлаа телефоноор “барагдуулсан” тул одоо хувийн ажлыг барагдуулах гэж ярьж гарав. Суурин телефоноор ярьсан зүйлийн захаас дурдвал, нэг хүнтэй “Чи миний захисныг амжуулж байна уу?” гэдэг сэдвээр арван минут, бас нэг хүнтэй бага насныхаа сонин үлгэр ярьж хорин минут, нэг “энхрий хонгор” гэж нэрлэгддэг хүнтэй, Дорж мед ирэх эсэх тухай дэчин минут ярилаа. Энэ бол их ярианы эх зах нь юм.

Суурийг ингэж суутал нь Гонгор орж ирээд, “За бас л байхгүй шив” гэхэд Суурь “Одоохондоо алга” гэж хариулав.

Гонгор хүйтнээр инээмсэглэж, “Одоохондоо алга гэсээр байгаад оргүй алга болох хүн юм даа” гээд гарч одлоо. Энэ үед Шуурай хэдэн дэлгүүр хэсээд гэртээ харьж, ямбатай гэргийдээ яндангий нь хөөлж, үнсий нь гаргаж амжсан байжээ. Шуурай ингэж шуурхайлж явахад ар талд нь албан ажил нь хийдэж, Шуурайг сураглаж арван хүн ирээд, Шуурайг асууж арван хүн утасдаад, дарга нь хоёр дахин дуудсан боловч, Суурь найз нь тухай бүрд нь аргалж, “Ойрхон яваа, ороод ирнэ” гэдгээс аваад “Толгой нь өвдээд эмчид очсон”, “Холдоогүй” гэх зэрэг олон шалтаг

зохиож овлон суудаг байжээ. Мань хоёр найз тэр хүнийг тэгж давлаа, энэ хүнийг ингэж дөнгөлөө гэж, олиггүй явдлаа нууж, ов зална магтаж баахан цаг нөхцөөдөг байжээ.

Гэтэл хоёр овтын арга баашийг тэр байгууллагынхан мэдсэнээр барахгүй, гүйдэг суудаг гэж нэр “өргөмжлөөд” бас зохих арга хэмжээ бэлтгэж байв.

Хэд хоногийн дараа Гонгорын ирэхэд өнөөх ушиартай өрөө цэлмэж, одоохондоо алга байдаг Шуурай гуай алга болоод, ороонд нь өөр хүн ажиллаж байв. Суурь гуай ч сууринаасаа ховхроод алга болжээ.

- Ингэх ёстой байсан юм... хэн ингэж өөрчлөв - гэсэн Гонгорын асуултад, тэр шинэ хүн

- Шүүмжлэл ингэж өөрчиллөө гэж хариулав.

(Л. Бадарч)

Notes:

1. ...байж.: = байжээ (see section 8. 9)
2. тийм ч учраас: 'for this reason'
3. олон дахин: 'many times, over and over again'
4. есөн цагтай уралдаад: 'having raced against (lit.: with) 9 o'clock'
5. амрыг эрье!: 'Greetings! How do you do!' (lit.: 'let's seek peace and contentment!')
6. санаа амар: 'don't worry! don't be anxious!'
7. шугамнаас аваад: 'beginning with ... and ruler'; the verb *авах* is most frequently translated 'beginning with, from that moment' when preceded by an ablative. Note that the author here follows popular usage (see section 0.10) and treats the word 'ruler' as if it had a fleeting -n in its stem.
8. хоёр гурвыг: 'and two or three things'
9. Суурийг хөдөлж...: see section 15. 1.
10. ...хээр суусныг: 'that (the car) was stuck out on the steppe'
11. арваад: 'about ten'

12. одоохондоо: 'just for a moment' (lit.: 'in its own little now')
13. За яадаг билээ: 'Well, what's happened (to him); what could he be doing?'
14. явчи(в): intensive form of явах
15. гарсан дор: 'immediately (he) had gone out'
16. захаас дурдвал: 'if one mentions just touching upon the topics...'
17. эх зах нь: 'the whole of the matter, the he and the she of it'
18. гэсээр байгаад: 'having continued to say'
19. гэдгээс аваад: 'beginning with saying...'
20. гэх зэрэг: 'etc., and such things'
21. зохих арга хэмжээ...: 'were taking (preparing) the appropriate measures'

LESSON 22

БЭЛДЭЭ БУУСАН НЬ

Есдүгээр сарын нэгэн юу юугүй тулжээ. Хотод хүйтэн бороо шивэрч, уулсын оройд будан суусан зэврүүн өглөө дугуйтай, явган, машинтай зэрэг элдэв хөсөгтэй хүмүүсийн хөдөлгөөний эрчим эрс түргэскээ. Төв замаар давхиж буй том улаан автобусны дотор чихэлдэн яваа олон улсын сэтгэл нэг л тайван биш.

Хүүхэд багачууд залуус хичээл сургууль, цэцэрлэг яслийн ажил эхэлнэ гэж их л хөөрүү шуугиантай. Аав эжий ах эгч нарын амьдрал хөдөлмөрийн сэтгэл агаар улиралтай хамт арай л илүү хариуцлагатай болсон шинжтэй.

Гэтэл хамгийн урд талын суудал дээр хойшоо харж налж суугаад, хоёр хөлөө зөрүүлэн жийсэн залуугийн хоёр гутал шагайгаа хүртэл шавар болсны нь харвал их л тэнэсэн бололтой, саарал цувныхаа кармаанд хоёр гарaa тохойгоо хүртэл шаах, далаа хавчсаныг ажвал даарсан нь илэрхий. Энэ залуугийн бусдаас ялгарах онцгой тал нь гэвэл? Сэтгэлдээ зорьж санааширсан юм огт үгүй, зөвхөн автобус дотор явагчдыг нэг нэгээр нь түргэн ажиглан өнгөрч, орсон гарсан хүмүүсийг хялав хялав бүртгээд, хааяа нэг гашуухан өвшээнэ. Уншигчаа! Би энэ залуугаа саарал цувт гэж нэрлэе.

Автобус зогсох цөөн хүн буух нилээн олон хүн нэмэгдэв. Урд талын хаалгаар зургаа орчмын насын хүүхэд нэг гартаа чиргүүлэн өргөж негее гартаа гурав орчмын насын хүүхэд тэвэрч, шар савхин мөнгөний сав ба том гэгчийн бор цаасан боодолтой юм торон саванд хийж, хүүхэд тэвэрсэн гарынхаа тохойд углан дүүжилсэн хүрэн пүүсүү дээлтэй тарган ягаан авгай орж ирээд амьсгаадаж сандарсандаа хэд хэд чанга ёолов. Гэтэл нүүрний суудалд суугаа хөвөнтэй цамц нөмөрсөн, хүрэ барьсан, туранхай, хөх өвгөн хангинуур сүх шиг дуу гарган:

- Саарал цувтай залуу минь, чи наад хүүхэдтэй хүн ядарч явахыг харахгүй байна уу? гэж олны дунд чанга зарлахтай зэрэг саарал цувт гэнэт цочиж огло харайн босоод хүүхэдтэй авгайг суулгав. Хоёр хүүхэдтэй авгай тавтай сууж аваад амарсандаа ахиад нэг сайн ёолов.

Саарал цувт маань тэр хүрз барьсан өвгенийг нүдний-хээ булангаар хараад, энэ муу хярсны мах шиг өвгэн намайг нэг сайн чадлаа, за гайгүй дээ чамайг гэж дотроо занан нүдэлж байтал залуугийн хөлийн өлмий дээр нилээн хүнд юм буухыг мэдэрвэл хүн гишгэж байгаа хэрэг биш, ямар нэг сүл юм унасан бололтой. Хэн унагаасан юу бол гэж бодвол, хоёр хүүхэдтэй авгайн юм болох нь гарцаагүй. Чухам юу байгаа бол гэдэг бодол саарал цувтын бүх мэдрэлийг эзэлжээ.

Хүмүүсийн хөдлөл түлхэлцээнийг ашиглан бөхийн тэм-тэрвэл том гэгчийн савтай юм байсныг мэдээд цувныхаа хормой дотуур дээш нь өргөж аваад ухарч эхлэв. Ухарч яваа замдаа хоёр хүүхэдтэй авгайг ажиглавал огт ч сэхиг авсан шинжгүй, ханцуйгаа ярж бугуйныхаа алтан цагийг хараад өвөр дээрээ суугаа хүүхдийнхээ хазайсан малгайг засав. Тэр авгайн алтан цаг, хуруунд нь байгаа алтан бөгж, хувцас бүх байдал ер нь чинээлэг байрын авгай болох нь танигдах тутам, торон савтай юм улам хүнд болох шиг бодогдоод түргэн ухартал баргил дуутай хүдэр хар хүн:

- Чи буруу тийшээ зүтгэсэн хайшаа залуу вэ? гэж айхтар цочоосон боловч, саарал цувт түр яг зогсох баргил дуутыг өнгөрөөж үргэлжлэн ухарсаар хойт хаалгын орчим иржээ. Автобус дараахи буудал дээр зогсов. Саарал цувт уг нь дахиад дервэн буудал явж гэртээ хүрэх ёстой ажээ. Гэвч гарзны эзэн түлхэж, олзны сэтгэл хатгаж, тэр буудал дээр буухаас өөр аргагүй болоод, бууж тодорхой чиглэсэн зүггүй нэг хэсэг алхаж явах замдаа хоёр хүүхэдтэй авгайг санахад ер нь нэгтэй үзсэн ч хүн шиг, тэр ч байтугай ямар нэгэн томоохон дэлгүүрийн кассанд суудаг авгай шиг ч санагдах хэл нь хөнгөрч, хүнгүй газар очиж олзоо задлан үзэхээр яарч шогших шахам алхаж, дэмий л гаднаас нь тэмтэрч үзвэл, гадуур нь цаасаар давхарлан боосон хатуу юм байгаа болохыг ойлгож, лав л муусайн хуучин даавуу хувцас биш гэж' мэдээд гудамжны булангаар тойров.

Хоёр хүүхэдтэй авгай тэр алдсан юмаа ч үгүйлсэнгүй мартаж, хүүхдүүдээ түүртэн сандарч автобуснаас бууж явааар нэгэн байгууллагын үүдэнд ирээд, бие тойруулж цэг хараад торон савтай юмаа автобусанд мартсанаа гэнэт санаж.

- Ээ! Уймраа өлөгчин! Юмаа автобусанд мартчиж! гэж хашгараад одоо яана? Өөрийн хоёр, хажуугийн айлын хоёр дөрвүүлэнгийнхий нь хаячиж! Одоо аль ч автобус гэж эрх явах билээ? Юугаа би ч мартчиж гэж сураглаж байх билээ гээд, нэг уур нь хүрч нэг инээд нь хүрч гайхаж зогстол, байшигийн хаалга нээгдэж танил эмэгтэй гарч ирэхэд нь мэндлэлцэж, юу хийж яваагий нь асуусанд тэр эмэгтэй цаг алдаж гарз шаасан байдалтай,

- Хүүхэд цэцэрлэгт оруулах гээд өтгөний нь шинжлүүлэх гэж ирсэн чинь өнөөдөр энэ шинжилгээнийхэн субботниктай гэнээ. Хүүхдийн өтгөн авахгүй, маргааш өглөө авах юм гэнээ. Тэгээд буцах явна гэж хэлснийг нь мань авгай дуулаад, ер нь гарзтай онц юм огт ч болсонгүй. Яхав маргааш өглөө дахиад авахад ямар байхгүй юм биш гэж бодоод дотор нь уухраад буцаад алхжээ.

Саарал цувт дөрвөн шил савтай олзоо тортон савтай нь хамт газар савчаад урам нь хугарч дахиад тавин мэнгэ байхгүй учир дөрвөн буудал явган алхах болсондоо бүр ч гутаж “шунал гэдэг муухай юм даа; хүний өтгөнийг хүртэл хулгайлж үздэг байна шүү. Миний энэ бэлдээ буучаад явааг хүн мэдвэл чухам би яана?! гэж ичсэн гутсандаа цайлан нүднийхээ нулимын цувныхаа ханцуйгаар арчив.

(Л. Вангтан)

Notes:

1. **юу юугүй:** 'quickly; at a moment's notice'
2. **явагчдыг:** явагч(и)дыг 'the goers' (accusative)
3. **нэг нэгээр нь:** 'one by one'
4. **уншигчaa!**: 'Oh, reader!'; the long vowel is here a vocative
5. **орчмын насны:** 'about the age of...; about ... years old'

6. том гэгчийн: 'very large'; see section 8. 10. c
7. хэд хэд чанга ёолов: 'groaned loudly several times'
8. зарлахтай зэрэг: 'at the moment he announced'
9. сууж аваад: 'having sat down; having accepted the seat and sat down'; see section 12. 16.
10. муу хярсны мах: term of abuse: 'flesh of the vile steppe fox'; note the n-stem in the declension
11. намайг нэг сайн чадлаа: 'did me a fine turn!; put one over on me!'
12. ямар нэг: 'some kind of ...'
13. өвөр дээрээ суугаа: 'sitting on her lap'; note that the reflexive suffix is added to the postposition
14. ер нь: 'in general; usually'
15. танигдах тутам: 'the more it became recognized; the more he realized'
16. дахиад дөрвөн буудал: 'four stops more'
17. буухаас өөр аргагүй...: 'There was no choice but to get off'
18. нэг хэсэг: 'a bit, a little'
19. нэгтэй: 'once before; somewhere'
20. тэр ч байтугай: 'let alone that; not only that, but ...'
21. марчиж(ээ): intensive form of мартах
22. эрж явах билээ: 'would (I) have to go and look for...'
23. дөрвүүлэнгийнхий нь хаячиж(ээ): 'I have lost that (thing) of the four of them'
24. нэг уур нь хүрч нэг инээд нь хүрч: 'alternately being angry and laughing'
25. гарз шаасан: 'having suffered a loss'
26. гэнээ: = гэнэ
27. авах юм: 'will have to take'
28. яахав: (here:) 'Well, no matter; what of it!'

29. бүүч(аад): intensive form of бүүх

LESSON 23

МОНГОЛ, АНХ БИЧИГ ҮСЭГТЭЙ БОЛСОН ТУХАЙ

12 дугаар зууны эцэс, 13 дугаар зууны эхээр монголчууд анх үсэг бичигтэй болсон тухай мэдээ байдаг. Гэвч энэ бол 13 дугаар зуунаас өмнө Монголд бичиг байгаагүйн баримт болохгүй. Гагцхүү түүхэнд анх тэмдэглэгдсэн мэдээ юм. Монгол анх бичиг үсэгтэй болсон тухай мэдээ Алтан товч, Юань улсын судар зэрэгт байдаг. Харчны Алтан товчид бичсэнийг дурдвал:

“Чингис хаан, Наймантай байлдах байх үед нэгэн хүнийг барьж авчирсанд түүний өвөрт тамга байв. Түүний хэлсэн нь: Би уйгур газрын хүн, нэр Таттунга. Миний эзэн тамгыг надад тушааж, эд идшийг гаргах ба оруулах явдлыг надад тушаасан билээ. Энэ тамгыг сайн хүнийг сонгох, зарлиг бичиг явуулах аливаа үйлд хэрэглэнэ” гэжээ. Цааш нь Хасар, Таттунгааг багш болгож бичиг үсэг заалгасан тухай бичжээ (Позднеевын эмхтгэсэн Монгол утга зохиолын унших бичгийн 145 дугаар нүүрт үз). Чингис хаан Найман аймагтай байлдах, Таттунгааг олзолж аваад түүгээр хүүхэд дүү нартаа бичиг үсэг заалгасан тухай мэдээ Юань улсын судрын 124 дүгээр бүлэгт бий.

Чингис, Наймантай байлдсан нь 1204 оны үед болсон хэрэг юм. Ганц энэ мэдээг баримталж монголчууд 13 дугаар зууны эхэнд бичиг үсэгтэй болсон гэж хэлэлцдэг. Гэтэл найман аймаг бол Монголын нэгэн аймаг бөгөөд хэдийд тэр бичиг үсэгтэй болсон тухай тодорхой мэдээгүй. Монголын баруун аймгууд урьдаар бичигтэй болсон нь ер нь лавтай хэрэг юм.

Тэд соёлжсон уйгур аймагтай ойр нутаглаж байсан учраас урьдаар соёлжих эхэлсэн бололтой. Хуучин монгол үсгийг нарийвчлан үзвэл Дүрвэд Торгуудын нэлэө нилээд үзэгдэнэ. Жишээ нь: долоон, олон гэх мэт үгс бий. Үүнд -долаан, олан- гэж Торгуудын хэлдэг ёсоор хуучин бичигт бичсэн байна. О-гийн дараа а байдаг нь

Торгуудын хэлний нэлэе мөн бололтой. Бас “күмүн, өбэр, өрлүгэ, дэбэл, эдүгэ” гэж хуучин бичгээр бичдэг. Энэ бас торгууд хэлний нэлэе байна. Халх нар “хүн” гэнэ. Нууц товчоонд “хүүн” гэдэг, Дүрвэд “күмн” гэдэг. Эдгээрээс үзвэл манай хуучин бичиг баруун аймагт эхэлж хэрэглэгдээд дараа нь бүх Монголд дэлгэрсэн бололтой.

Монголчууд бичиг үсгийг хэрэглэж байсан тухай өөр нэг мэдээ Нууц товчоонд бий. Нууц товчооны 203 дугаар зүйлд Чингис хааны зарлиг болсон нь: “Шихи-Хутугийг бүх улсын доторхи хулгайг цээрлүүлж, худлыг мохоож, үхүүлэх ёстойг үхүүлж, яллах ёстойг яллах бай гэх бүх улсын дээд заргач болгов. Бас нийт улсын өмчийг хувдааж, заргыг шийтгэж, түүнийгээ хөх дэвтэрт бичиж дэвтэрлэгтүн. Надтай зөвлөж, Шихи-Хутугийн шийтгээд цагдаан цаасан дээр хөх дэвтэрт бичиж дэвтэрлэснийг ургийн урагт хүртэл хэн ч бүү өөрчилтүгэй” гэж зарлиг болжээ.

Бас 1220 оны орчим Чингис хаан, Хятадын даосын шахны бомбо Чан Чуньтай ярилцсан зүйлийг уйгур үсгээр бичсээд ав гэж шадар бараа бологчдод тушааж байсан байна. Энэ мэтээс үзэхэд монголчууд 13 дугаар зууны эхний үед уйгур бичгийг нилээд хэрэглэж байсан нь илт байна.

Монголын бичгийн жинхэнэ дурсгалт бичиг бол 1220 оны үес хадан дээр сийлсэн Чингисийн чуллууны бичиг мөн. Түүний дараахь нь 1246 онд бичсэн Гүюг хааны тамгын бичиг юм. Мөн 1257 онд Мөнх хаанд зориулан бичсэн чуллууны бичиг саяхан Хөвсгөл аймгаас олдов.

1269 онд Чингисийн ач хүү Хубилай сэцэн хаан, уйгур бичгийг халж, түвд үсгийг дууриалган дөрвөлжин үсгийг зохиолгон хэрэглэсэн. Гэвч энэ дөрвөлжин үсэг, бичихэд нуршуудалтай учир их дэлгэрч чадсангүй.

Харин уйгур үсэг монголчуудын хэрэгцээг олон зуун жил хангасаар иржээ. Уйгур үсгийг монгол хэлэнд зохицуулан хэрэглэхэд Түвшийн Сажа бандид Гунгаажалцан, Уйгурын бандид Чойжи-Одсэр хоёр нилээд оролдсон ажиллахээ. Үүн дээр 13 дугаар зууны эхэнд хятад үсэг хэрэглэж байсан мэдээг нэмбэл 13 дугаар зууны үед монголчууд нь хятад, уйгур, түвд үсгүүдийг зэрэгцүүлэн хэрэглэж байжээ. Уйгур үсэг бол тодорхойгүй: о, у; ө, ү; д, т; х, г; ч, ц; ж, з, я зэрэг дуудлагыг ялгаж чаддаггүй байсан. Гэвч энэ олон дуудлагыг ялгаж чадахгүй хоцрогдсон бүдүүлэг тал нь Монголын олон аялгуут хэлэнд тохирсон бас нэг сайн тал болж байлаа. Жишээ нь: Халх

нар үгийн эхний д, т; х, г авиааг хутгаж хэлдэг. Бур-иад нар ө, ү авиааг хутгаж хэлдэг. Бас о, у хоёрыг хутгаж усыг “ос”, өндөр гэхийг “үндэр” гэдэг ч бий. Халх нар “зам” гэнэ. Өвөр монголд “хам” гэнэ. Баруун монголд “ям” гэнэ. Уйгур үсгээр бичигдсэн “зам” гэдгийг энэ гурван янзаар унших бололцоог олгожээ. Иймээс олон аялгуут аймгууд өөр өөрийн хэлдгээр унших боломжтой байжээ. Хуучин монгол үсгийн дутагдлыг Монголын эрдэмтэн сэхээтэн нар засах гэх хэдэн зуун жилийн турш оролдсоор ирэв.

Чойжи-Одсэр п, ш хоёрыг нэмэв. 16 дугаар зууны үед Ашуш гүүш галиг үсгийг зохиов. Энэ нь гадаадын үгийг бичихэд зориулсан арваад шинэ үсэг юм. 1648 онд Ойрдын Зая бандид тод үсгийг зохион гаргав. Монголын Өндөр гэгээн 17 дугаар зууны эцсийн үед соёмбо үсгийг зохиосон. 20 дугаар зууны эхэнд Буриадын Агваан хамбо монгол үсгийг тод болгох, шинэ үсгийг зохиосон. Энэ бүгдээс үзвэл монгол үсгийг тодорхой сайн болгох гэж олон зуун жилийн турш оролдсоор иржээ. 1930 онд латин үсэг хэрэглэх туршсан ба 1942 онд орос үсгээр үндэслэсэн шинэ үсгийг авч энэ асуултыг шийдвэрлэв.

Notes:

1. түүний өвөрт тамга байв: the Mongols carry things in the front of their gowns, using the space between the body and the breast flap as a pocket.
2. күмүн, өбэр, өрлүгэ, дэбэл, эдүргэ: in Modern Mongolian: хүн, өөр, өглөө, дээл, одоо
3. эдгээрээс үзвэл: 'judging from these (things); as one can see from these things'
4. зарлиг болох: a term used with reference to exalted persons with either the meaning 'to order' or simply 'to speak'
5. үхүүлэх ёстойг үхүүлж: 'executing whoever is to be executed'
6. ургийн урагт хүртэл: 'down to the last generation'
7. үүн дээр: 'in addition to this'
8. “ям”: Actually the Western Mongolian pronunciation of this word is ‘zam’, but the author has no way of writing this since the Modern Mongolian letter 3 represents the sound ‘dz’
9. өөр өөрийн: 'of each separate; each their own'

LESSON 24

ХОРЛООГИЙН ЧОЙБАЛСАН

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын ерөнхий сайд, Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хорооны Улс Төрийн Төвчооны гишүүн, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Их Хурлын депутат, манай нам ба ард түмний жолоодогч, манай аврагч хамгаалагч бөгөөд түшиг тулгуур болсон Зөвлөлт Холбоот Улсын үнэнч хань Хорлоогийн Чойбалсан удтал хүндээр өвчилсний дараа 1 дүгээр сарын 26-нд нас барав.

Хорлоогийн Чойбалсан 1895 оны 2 дугаар сарын 8-нд ядуу ардын гэр бүлд төржээ.

Гадаадын боолчлогчдын тэсвэрлэшгүй хүнд дарлал ба балмад харгис явдлууд болон феодалуудын хатуу ширүүн мөлжлийг бага насандаа гатааж туулсан Чойбалсан өөрийн ард түмнийг гадаадын эзлэгчид ба феодалуудын дарлалаас чөлөөлөх үйл хэрэгт бүх амьдралаа зориулахаар эрс шийдвэрлэсэн юм.

Нөхөр Чойбалсан 1918 оны эцсээр хувьсгалт нууц бүлгэмийг байгуулав. Энэ бүлгэм нь удалгүй Сүхбаатарын удирдсан хувьсгалт шууц бүлгэмтэй нийлэв. Энэ үеэс Сүхбаатар-Чойбалсан хоёрын хамтарсан хувьсгалт үйл ажиллагаа ба чин үнэнч дотнын нөхөрлөл эхэлсэн юм.

Монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтолцоны төлөөний тэмцлийг манлайллан удирдсан Монгол Ардын Хувьсгалт Намыг Сүхбаатар, Чойбалсан нар 1921 онд байгуулав.

Сүхбаатар, Чойбалсан тэргүүтэй Монгол Ардын Хувьсгалт Намын удирдлагын дор Оросын пролетари нарын шийдвэрлэх тусlamжтайгаар Монголын ард түмэн, 1921 онд ардын хувьсгалыг мандуулж, гадаадын боолчлогчдыг өөрийн орноос хеен зайлуулав.

Их Зөвлөлтийн ард түмэнтэй манай ард түмэн үүрд эвдэршгүй ах дүүгийн ёсоор найрамдахын үндсийг

Сүхбаатар, Чойбалсан нар тавьсан юм. Сүхбаатар, Чойбалсан тэргүүтэй Монгол Ардын Хувьсгалт Нам, ардын ялалтат хувьсгалыг мандуулаад манай тусгаар тогтносон ардын төрийг байгуулж бэхжүүлэхэд шинэ ялалтууд өөд манай ард түмнийг жолоодов.

Аймшиггүй Сүхбаатар нас барсны дараа нам ба улсыг удирдах ажлын бүх хүнд хүчир нь нөхөр Чойбалсан дээр тохогдсон юм. Чойбалсан, хувьсгалын бүх дайснуудтай цогт хувьсгалч эвлэршгүй тэмцлийг хийж манай намыг цуцалтгүй бэхжүүлж, хатуужуулсан юм.

Манай нам, Ленин, Сталины сургаалыг баримтлан, Чойбалсангийн удирдлагын дор манай орныг капиталист биш замаар хөгжүүлэх ганц зөв бодлогыг сонгон авлаа.

Манай эх орон 30 гаруй жилийн турш эрх чөлөөтэй тусгаар тогтнон, хөгжих цэцэглэхдээ олсон бүх гайхамшигт амжилтууд бол нөхөр Чойбалсангийн нэртэй шууд бөгөөд нягт холбоотой юм.

Нөхөр Чойбалсан хамгийн идэвхтэй оролцож, зоригжуулж, зохион байгуулаагүй ямар нэгэн чухал явдал манай нам ба улсын түүхэнд үнэхээр нэг ч байхгүй юм. Нөхөр Чойбалсангаас их Зөвлөлт Холбоот Улсын ард түмэнтэй манай ард түмний найрамдлыг бүх талаар бэхжүүлэн, хөгжүүлсэн бөгөөд энэ найрамдал бол манай улс эрх чөлөөтэй тусгаар тогтнон оршихын баталгаа, манай бүх амжилтын үндэс, социализмд орох замаар урагшaa явах манай амжилттай давшилтын баталгаа мөн юм.

Герман фашистын эзлэгчдийн эсрэг Зөвлөлтийн ард түмний эх орны дайны өдрүүдэд Монгол-Зөвлөлтийн ард түмнүүдийн агуу их найрамдал онц тод бөгөөд хүчтэй илэрсэн юм. Монгол Ардын Хувьсгалт Нам ба нөхөр Чойбалсан зоригжуулж удирдсан монголын ард түмэн, нийтийн дайсан германы фашизмыг ялах хэрэгт нь ах дүү Зөвлөлтийн ард түмэнд бүх чадлаараа туслах явдлыг өөрийн гол зорилт гэж эх орны их дайны анхны өдрүүдээс эхлэн үзсэн юм.

Манай ард түмэн, манай орны зэвсэгт хүчин, Монгол Ардын Хувьсгалт Нам ба нөхөр Чойбалсангийн удирдлагын дор, агуу их Зөвлөлтийн ард түмэнтэй ах дүү ёсоор хамтран найрамдах, Зөвлөлтийн баатар армитай хөтөлцөн явж, японы империализмийг бутцоих хэрэгт бүх чадлаараа өөр-ийнхөө хувь нэмрийг сруулсан юм.

Нөхөр Чойбалсан, манай орны бүх хөдөлмөрчийн олон түмэн ардтай өргөн дотнын холбоотой байсан юм. Манай

ард түмэн өөрийн жолоодогч эцэг бөгөөд хань нөхөр Чой-балсангаа хэзээд халуун дотноор хайрладаг юм. Манай эх орны тусын тулд ба цэцэглэлт, манай орны хөдөлмөрчид нэг бүрийн тусын тулд зориулсан нөхөр Чойбалсангийн гайхамшигт хувьсгалч зүтгэлийг манай ард түмэн өндөрөөр үнэлсэн юм.

Манай ард түмэн, аугаа их ач гавьяаг нь тэмдэглэн нөхөр Чойбалсандаа Бүгд Найрамдах Монгол Ард Улсын баатар гэдэг дээд цолыг хоёр удаа өргөмжлөн олгосон юм. Нөхөр Чойбалсан, Сүхбаатарын одонгууд, байлдааны улаан тугийн одонгууд, хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, алтан гадас одон ба бусад медалиудаар шагнагдсан юм.

Монгол ба Зөвлөлтийн ард түмний аугаа их найрамдал ба хамтын нягт ажиллагааг бэхжүүлэх, эх орны их дайны өдрүүдэд Зөвлөлтийн ард түмэнд туслах ажлыг зохион байгуулсан ба японы имперализмийг бутцоихын төлөө тэмцэлд гарамгай гавьяа байгуулсныг тэмдэглэн СССР-ийн Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн газраас нөхөр Чойбалсанг Лениний одонгоор хоёр удаа, улаан тугийн одонгоор хоёр удаа, Суворовын нэгдүгээр зэргийн одон ба медалиудаар шагнасан юм.

Нөхөр Чойбалсангийн гайхамшигт бүх амьдрал ба үйл ажиллагаа бол манай намын гишүүд нэг бүрд, манай орны шудрага хөдөлмөрчин нэг бүрд ард түмэндээ амь бие хайрлахгүй зүтгэх манай эх орны тусын тулд алдарт шинэ гавьяа байгуулахад биднийг уриалан дуудсан хурц жишээ юм.

Манай хайрт жолоодогч, манай хань бөгөөд дайчин нөхрөөсөө хагацсан явдалд бид хязгааргүй харамсан гашуудна.

Notes:

1. Хорлоогийн Чойбалсан: the custom in Mongolia is to precede the personal name by the name of the father or the clan of the person in question in the genitive case; in the case of Choibalsan, his father's name was Khorloo

2. 1 дүгээр сарын 26-нд: Choibalsan died on January 26th, 1952

3. урагшaa: 'forward'; note the reflexive suffix

4. хөдөлмөрчин олон түмэн: 'the proletarian masses'
5. амь бие хайрлахгүй: 'not sparing their life; not sparing themselves'

LESSON 25

НААДАМЧИД

Миний танил нөхөр Сүрэн, сумын дунд сургуульд багшилдаг юм. Хөдөө ажлаар яважын далимаар би түүнтэй санамсаргүй учраад тэднийд очлоо. Тэр бид хоёр байшингийн сүүдэрт зассан бандан дээр суугаад хууч хөөрч байлаа.

Тэтгэл бидний дэргэдүүр жороо морьтой хоёр хүн тэмүүлэн өнгөрлөө. Нэг нь зулзаган хус шиг гуалаг биетэй нилээд царайлаг залуухан хүүхэн байлаа. Негеө нь холтсоор сийлсэн зормол мэт барзгар хүрэн царайтай, монцгор улаан хамартай, нүсэр тарган биетэй эр байв.

Хоёулаа луун хээтэй хятад улаан торгон дээл өмссен нь гоёл биш, цам майдрын хувцас шиг санагдана. Бас хулсан өнгөт тарган жороо морьд зүс нийлүүлэн унажээ.

-Энэ аав охин хоёр дээл хувцас, морины зүсээ хүртэл сүрхий хуарлуулж дээ - гэж бодсоноо хэлтэл найз маань:

-Ха-ха-ха. Аав охин хоёр гэнээ чи харин... гэж элгээ хөштөл инээгээд - энэ чинь б дугаар багийн баян Дондог гуай залуу авхайтайгаа наадамд намъж яваа нь энэ байхгүй юу гэсэнд би тоймгүй гайхаж:

-Юу гэнээ?! Эр эм хоёр гэж үү? Хачин юмаа, ийм гуа залуу хүүхэн энэ хөгшин хар хүнтэй яагаад суучихсан юм бол? гэж асуулаа.

-Гайхалтай байгаа биз. Энэ инээдтэй ч түүх, гунигтай ч намтар байгаа юм даа гээд түүний ярьсан нь:

-Би, энэ нутгийн хүн болохоор цөмий нь мэднэ.

Багадаа би энэ Дондог гуайнд нэг очлоо. Өглөө эрт ч юмсан. Дондог гуай тэр үед хориод настай залуухан хар хүү. Би ч бүр хүүхэд байжээ.

Дондог гуай гэрийн хоймор ширдэг дээр гудас дэвсэж унтсан бололтой дэнгэх босч байлаа.

Зүүн талд нэг өргөн бандан ор харагдах нь эхийнх нь ор бололтой.

Нэг бууралтаж яваа үстэй, духныхаа шар үсийг мэлзэн халзан болтол хойш нь шуух зулгаасан туранхай хөгшин

авхай бяслаг шахаж байлаа. Тэгтэл Дондог гуай “чи муу хөгшин гичий намайг зарж арьс махы минь тасдах гэлээ” ч гэх шиг загнаж гарлаа. Хөгшин авгайн уйтгартай хонгор нүдэнд гаслан хүлцэл, айх байдал зэрэгцэж, орон дээрээ үг дуугүй суув.

Дондог гуай, “хөгшин гичий чи малдаа намайг зарах гэж хар өглеөгүүр хон хэрээ шиг бархирна гэнээ” гэж авхайг нэг халт цохиж аваад гарч одлоо. Авгайн гал нь буурсан нүднээс нулимын мэлмэрэн гарч, алгуурхан урсаар хацрынх нь хонхорт тогтов.

Би хөгшин авгайг их өрөвдөх золтой л уйлчихсангүй. Чадалтайсан бол Дондог гуайг багалзуурдмаар л санагдаж билээ.

Тэгээд гэртээ хариад: “Эгчээ! Дондог гуай ямар муухай хүн бэ. Ээжийгээ хөгшин гичий гэж загнаж зодоод байх юм” гэж эгчдээ хэлсэн минь манайхан нир хийтэл инээж эгч ч бүр элгээ хөштөл инээж сунах унасанд би их гайхаж бараг л уурлах шахаж билээ. Тэгсэн чинь эх нь биш эхнэр нь юмсанжээ.

-Уухай! Дондог гуай чинь тэгвэл наргидаг эр юм даа гэж би улам сонирхон соислоо.

-“Наргидаг” эр ээ! Дондог гуай их ядуу айлын хүүхэд боловч баяжих их дуртай хүн байжээ. Тэгээд баян Тагар гэгчийн бэлбэсээрсэн нэг хүүхэнтэй гэрлэсэн юм байж. Авгай нь өөрөөс нь үе мултарсан эгчмэд юм байжээ. Аих тэднийд хүргэн ороод Дондог гуай эхнэртээ сайн ч юм шиг, айдаг ч юм шиг үгнээс нь гардаггүй байсаннаар барахгүй, хүнд ярихдаа их хайртай гэдэг байжээ.

Харин эцэг хөгшний нь өнгөрснөөс хойш Дондог гуайн янаг зан бас өнгөрч эхнэрээ аашлан загнах, нүдэх зодох болж билээ. Дондог гуайд эхнэр нь биш эд хөрөнгө нь хэрэгтэй байсан дээрээс тэгж хувирчээ.

Нэг хүү төрснийг хүнд үрчлүүлжээ. Хөгшин авгайгаас гарсан хүүгээ өөрийн хүүхэд гэхээс их ичдэг байв. Дондог гуай ямагт айл хэсэн завхайраад гэрт орохoo больсноор барахгүй, ор дэвсгэрээ хүртэл тусгайлсан байжээ. Тэр хеерхий донгио дорой авгайг харж тэтгэх ах дүүгүй, яая гэх вэ? уйлахаас өөр мэхгүй болжээ. Тэр үеэс авгай улам ч түргэн өтөлж, өнгө зүс алдаад үс нь цав цагаан болжээ. Дондог гуай “буурал эмгэнээ” буг болсон мэт жигших бөгөөд амьтны ярихаар бол “энэ муу хөгшин шулам үхэж арилаасай” гэдэг байсан гэнэ.

Дондог гуайн хар хэл биелж хөөрхий тэр авгай Дондог гуайг 37 хүрч хүүгээ 17 нас хүрэх жил мажийж, Дондог гуайн санааг амрааж билээ.

Үхсэний хохь, амьдын зол болдог нь төрөлхийн ёс болохоор Дондог гуай ч хөдөөгийн ардуудын ярьдгаар “юмны эзэн сумны занги” болж авчээ. Тэгээд ёстой “харгал” гэдгийг эрж хайх болж.

Хүнд өргүүлсэн хүү нь 8 дугаар ангид байхдаа хамт сургуульд явдаг нутгийнхаа нэг охинтой үерхдэг байв. Тэднийх дунд чинээний айл боловч эцэг эх нь ядуу хоосон гэж үглэн улиглах дуртай улс байжээ.

Нэг жил, тэр охин хичээлдээ ирсэнгүй. Дондог гуайн айлд өргүүлсэн хүү нь түүнийг сургуулиасаа гарчихсанд харамсаж захиа бичсээр байв. Тэр хоёр багаасаа нэг дор эрхлэн өссэн үе наасны багачуудын дотно найз нар байжээ. Тэгээд найз охин сургуулиа орхиод бас захианы хариу ч эс бичихэд тэр хүү их л гайхан бас харамсаж л байжээ.

Тэр хүү 9-р анги тэгсөөд нутагтаа амрахаар ирэхдээ төрүүлсэн эцгийнх нь улаан зам дээр дайралдсанд ороод гарах гэж шийдхээ.

Ортол их гайхалтай юм үзжээ. Эцэгтэйгээ мэндэлтэл өнөөх үерхдэг охины нь нүүр улаан чавга шиг болоод инээх уйлахын алиныг ч мэдэхгүй дэмий л золгооор гар сарвайсанд хүүгийн зүрх нь пал хийж, бас ичин улайгаад гар зөрүүлэж ядаж ганц ч үггүй дув дуугүй байцгааж цайгаас нь амсагч болоод мордож оджээ. Тэр хүү нутагтаа дахиад огт ирээгүй, Зөвлөлт Холбоот Улсад эмнэлгийн дээд сургуульд явчихсан юм гэнэ билээ. Тэгээд Дондог гуай залуу гэргийгээ эрхлүүлэх гэж яггүй зовдог гэнэ. Тэр хүүхэн Дондог гуайгаар өглөө босгодог гэнэ. Хамаг ажлаа хийлгэдэг гэнэ. Үнээгээ хүртэл ивэлгүүлдэг гэнэ. Хөгшин дүх гэж харааж ерөөх, аашлах загнах нь ч бүр жигтэй гэнэ. Байсхийгээд л хүүхэн гүйгээд харьчихдаг гэнэ. Өнгөрсөн жилийн наадмаар тэр хүүхэн унах явсан жороо морио зарчихаад нэг залуу дагаад аймаг орчихсон юм гэнэ. Эргэж ирээд хүүхэн Дондог гуайн аргадан гүйснаар дахин суусан боловч энэ жил нэг пайр дээр тэр залуу нь баянд агсагнаж, Дондог гуайн багалзуурыг шахаж сандаргасан гэнэ билээ. Тэхэд нь авгай нь учиргүй инээж нэхрэе уурлахад нь:

-Хөгшин дүх минь чи залуу хүний гарын бяр даахгүй байж юунд хүн рүү сарвалзсан юм бэ? Хохь чинь, заяа

чинь гээд огт тоогоогүй юм гэнэ билээ. Гэвч салаад явчихгүй нь эгдүүтэй хэрэг. Бодвол тэр хүүхэн бас л Дондог гуайн аргаар Дондог гуайн буянг завших гэж тэс-гэлгүй хүлээн “энэ улаан хамартай хөгшин чөтгөр бушуухан ороосой” гэж “ерөөл” уншиж явдаг байлгүй дээ.

(М. Гаадамба)

Notes:

1. далимаар: ‘by a favorable chance’
2. элгээ хөштөл: ‘(laughed) until she split her sides’
(lit.: ‘until her liver became numb’)
3. байхгүй юу: ‘isn’t it?'; юу is here the interrogative particle
4. юмаа: = юм аа; аа is here only an emphatic exclamation
5. суучих(сан): emphatic form of суух
6. чадалтайсан бол: чадалтай -(a)сан бол; ‘if I had been able'; (a)сан is a verbal noun from the defective auxiliary verb a- ‘to be’
7. тэгвэл: ‘in that case’
8. өөрөөс: ‘than himself’
9. хүнд үрчлүүлжээ: ‘caused a stranger to adopt (him)’
10. гэхээс: ‘he was ashamed of ... ’; note that the ablative case is used with the verb ичих
11. яая гэх вэ: ‘what could she do?’
12. амьтны ярихаар бол: ‘according to people’s talk (he was saying...)’
13. хар хэл: here: ‘vicious talk’; freely: ‘... who danced to the tune of D.’s vicious talk.’
14. нэг дор: ‘together; at the same time’

15. багачуудын дотно...: the genitive here expresses a superlative: 'were the most intimate friends of (all) the children (who...)'
16. 9-p: = есдүгээр
17. эцгийнх нь: '(when he came upon) his father's ...'
18. улаан зам: 'equator'; here probably 'halfway'
19. ороод гарах гэж шийджээ: 'he decided to drop in'
20. дув дуугүй: 'completely quiet, without a sound'
21. байцгааж: plurative form of байх
22. амсагч болоод: 'having pretended to taste'
23. байсхийгээд: 'having suddenly discontinued (it); suddenly giving it all up'
24. харьчихдаг: intensive of харих
25. наадмаар: 'during the naadam'
26. зарчихаад: intensive of зарах
27. аймаг орчихсон: 'went off to the aimak (center)'
28. байлгүй: 'without stopping'; here; '... and so she keeps on waiting impatiently and reciting the yörööl: ...'. The suffix -лгүй added to a verbal stem means 'without doing...; not doing...'.

LESSON 26

ТАС

Гадас мэт шовх улаан хадны орой дээр цагаан толгой-той өвгөн тас, алд дэлэм урт далавчaa ядарсан байртай хумхиад сууж, эргэн тойрон хэдэн зуун бээрийн тэртээ цэлийн униартагч хөрст алтан дэлхийг шилэн үрэл шиг цэхэр нүдээрээ ихэмсгээр ажиглах нь амарлингүй бардам ажээ. Навтгар цагаан толгойгоо хааяа хөдөлгөх, цагаавтар шингэн хеөмий нь салхинд сэргэлзэнэ. Тэр тас энэ хадан дээр үд дундын үед дандаа сууж амардаг боловч хүн түүнийг тоосонгүй. Бэлэн хоол эрж наасаа элээсэн өвгөн тасын үзэж өнгөрүүлсэн амьдрал хүнд юугаараа сонин байх аж даа. Гэвч тасын амьдрал хачин юм. Бүх насыхаа турш бэлэн хоол хайх дэвэн дэлхийг хэсдэг болохоороо, гэлэн шувуу гэж нэрлэгдсэн ажээ.

Гозгор улаан хадны оройд үд дунд түр амсхийдэг тэр тас, алс холмын иэгэн цаст ууланд үүргэй боловч өдөртөө хэдэн мянганы тэртээ хүрч хоол хайдаг байжээ.

Үд дундын халуунд хадны оройд хэсэг зуур үүрэглэсэн юм шиг сууж байснаа, аажмаар далавчaa дэлгэх дэвсхийн босдог байв. Босмогц далавчaa дахин дахин дэвж ядуу-зай гэх болгоомжилсон мэт, алгуурхан эргэлдэж, эргэх тутам дээшилсээр үзэгдэхгүй болтлоо хөөрнө. Тэгж асар өндөрт гаравч, газар дээр хаана сэг гарсныг андахгүй үздэг байлаа.

Хүн усан нүдтэй, тас цусан нүдтэй гэж хуучны нэг үг байдаг. Хүн усыг олж харахдаа сайн бол тас цусыг юуны урьд олж хардаг амьтан юм. Алтайн ууланд нисч явахдаа Дориодын өргөн талд хонь хариулаад, алчуур шаглах суу-гаа хүүхний хатгамлын хээндэх улаан утсыг ч үздэг байж юн магад.

Өвгөн тас тэр нүцгэн хадны орой дээр үдэшдээ дахин нэг сууж амсхийдэг байжээ. Тэрхүү хадны орой өөрийн нь толгой шиг цайвар болжээ. Зуудах жилдээ тэнд сууж

amarч байгаа тасыг амьдралын тийм олон жил элэсэн амьтад гэх хэн таах вэ! Түүнтэй нэгэн адил тэр зуун жилийн турш нүгэлт орчлон хичнээн өөр болсныг тас мэддэггүй байлаа. Гагцхүү өндөр хадны орой дээрээс тэртээ дор бэлчин тарсан хонь мал, хүмүүсийг урт насныхаа турши санамсаргүй ажих суудаг байхээ.

Гэтэл тасын нас өвөгрөх тутам шороот замбуулинд хоол ховордох болжээ. Тэртээ олон жилийн цаана орчлон дэлхий их өөр байж билээ. Юунаас ч болдог юм бэ, бүү мэд, хүмүүс хоорондоо дайтах, бие биеэ алж, морь малын сэг хөглөн, дарийн утаяа хааяагүй үнэртдэгсэн. Тэд чухам яагаад тэгж бие биенийгээ сүйтгэдгийг тас мэдэхгүй боловч тэгдэгт нь хүмүүст баярладаг байхээ. Хүмүүсийн тэгж дайтахад нь тас хамгийн бэлэн хоолтой учирдаг байв. Дайнгүй цагт ч гэсэн өвчин тахлаар хярсан мал, хүн зэндээ дайралддаг байв. Тасыг тэгж бэлэн хоолтой залгуулсан юм нь хижиг, томуу гэдгийг мэдэхгүй боловч хувь заяа ихтэйнх гэж өөртөө найддаг байсан бийз. Бас газар усны шүтлэгтэнгүүд үхсэдийг тасын саварт атгуулахаар хээр орхидог байлаа. Хүний сүнсийг тас диваажинд хүргэдэг юм гэж тэр шүтлэгтэнгүүд итгэдэг байсны нь тас яаж мэднэ.

Ингэж газар дэлхий үхдэл сэгээр дүүрэн байсан тэр үеэс хойш өчинөөн течнөөн жил өнгөрлөө. Жил ирэх тутам бэлэн хоол ховордох, хүмүүс хоорондоо дайтахын оронд байгаль ертөнцийг хувирган захирч, нэг өдрийн дотор олон зуун үхдэл гаргадаг тэрхүү хорсголт “дайн” сая сая хүний гарти тас атгуулжээ. Нэгэн агшны дотор өчинөөн үхдэл гаргадаг өвчин тахал бас л тэр “дайнтай” хамт бяц атгагдсан ажээ. Сүнсээ диваажинд хүргэх юмсан гэж хүмүүс зовдгоо болж, сарны зүг, нарны зүг сүнсээ биш, өөрийгөө нисгэхээр завдах болсон байжээ.

Өвгөн тас өдөржин хөх огторгуйд эргэлдэн нисэвч, бэлэн хоол олдохоо байж, амран суудаг гозгор хадаа ч мартахад хүрэв.

Нэгэн өдер тас ядрахын туйлд хүрч мэнхүү хаднаа амрахаар доошлон иртэл, зуун жил сууж амарсан тэр хад нь алга байлаа. Тэр хадны оронд асар өндөр яндантай үйлдвэр босож улаан оч үсэргэсэн утаяа тэрхүү яндангийн гүн хар амнаас оргилон байлаа. Энд тэндгүй байшин барилга, мод цэцэрлэг, элдэв машин ярайн үзэгдлээ. Тэртээд галт тэрэг сунагар урт цуваагаа чирэн хурдалж, өргөн бор

харгуйгаар тариа ачсан машинууд тоос татуулан давхилдаж байв.

Өвгөн тас сульдан ядравч, өлөн ходоод хоосны эрхээр дээш хөөрөв. Улам дээш хөөрмөөр санагдах, эргэн эргэн хөөрөв. Бүүр нүднээ үзэгдэхгүй өчүүхэн цэг шиг болтлоо хөөрөв. Тэгэвч сэтгэл ханасангүй. Бүх орчлон дээр юу байгааг үзэхгүйц, болж л өгвөл, бусад гараг дээрх бэлэн хоол, үхдэл сэгийг харахуйц дээр гаражыг тэр зоржжээ. Эцсийн хүчээ гарган дээшлэхэд нь гэв гэнэт нүдий нь цийлгэр ус бүрхэж юм харахгүй болов. Эргэн тойронд бэлэн хоол ер үзэгдэхгүй боловч, хaa нэг газар бэлэн хоол байх ёстой гэдэгт зөнег тас итгэжээ. Тэртээ дээр өдий төдий үхсэн мал байх шиг санагдах, тэр зүг улам яаран хэмжээгүй дээр гарч явтал хүчтэй салхи түүнийг сэанс шиг эргүүлж үе мөчий нь тас няс хийтэл хугачиж, өд сөдий нь хярган тасчиж, авах юмгүй болгов. Ингэж агуу их бэлэн хоол хайгчийн биенээс ширхгийн төдий өд ч шороот газар дээр үлдсэнгүй. Тэр зөнег дээшлэн дээшилсээр салхин королд орчихсон байжээ.

Notes:

1. болохоороо: 'by becoming'; i.e., 'as a consequence of . . .'
2. хатгамлын хээндэх...утсыг: 'the thread which is in the design of her embroidery'; see section 13. 6.
3. юун магад: (freely:) 'that's for certain'
4. өвөгрөх тутам: 'the older he grows'
5. бүү мэд: 'who knows!', heaven knows!'
6. үнэртдэгсэн: this suffix expresses a past habitual act; it is composed of the verbal noun in -даг plus the past -сан form of the auxiliary verb а- 'to be', which here being enclitic changes to conform to the vowel quality of the stem of the word
7. хувь заяа ихтэйнх: 'that which belongs to one having a great fate, destiny'
8. газар усны шүтлэгтэнгүүд: 'shamanists, believers in local genii'
9. сая сая: 'millions and millions'

10. хээр орхидог: An old Mongolian funeral custom was to drag the corpse on a platform of poles behind a horse while galloping furiously out onto the steppe. The rider would make a large circuit and return home without investigating where the body fell. The corpse was then left on the steppe to be devoured by wild animals.

11. энд тэндгүй: 'everywhere'

12. үзэхүйц/харахүйц: these forms carry an equative meaning 'to the point of seeing; as much as seeing'

13. дээр гарах: 'to climb, to ascend'

14. гэв гэнэт: 'all of a sudden'; see section 13. 3.

15. хaa нэг газар: 'some place, somewhere'

16. ед сөдий нь: the second word is a reduplication of the first word, with an C prefixed; this type of reduplication is quite common in Mongolian (as it is in Turkish and some other languages); the resulting shade of meaning is not easily translatable. The most expedient way is simply to translate the basic word as plural, i. e., 'his feathers'. This kind of construction is also frequently reduplicated with an M prefixed. If the word has an initial consonant, it is dropped in the second part of the reduplication: цай май 'tea; tea and such things'.

LESSON 27

ӨЛЗИЙТИЙН ХЭЭР

Би бага байхдаа нэг зүн Өлзийт уулын өвөрт нутаглаж байгаа нагац ахындаа эхийн хамт айлчилж очив. Өдрийн халуун буурч, нар баруун тийш тонгойж байв. Нагац ах, авгай хоёр, манай ээж гурвуул гэрийн сүүдэрт суугаад цай ууж, хууч хөөрч байв. Бид хэдэн хүүхэд мөн гэрийн дэргэд чулуугаар гэр бариад тоглож байв. Орчин тойрон чив чимээгүй намуухан сэргүүн үдэш ойртох байв.

Нагацын авгай гэнэт яаралтай босч гэртээ ороод хувин дүүрэн сүүтэй цайг бас нэг тавагтай цагаан идээний хамтаар барин гарч ирлээ. Энэ цай идээгээр яах нь юм бол даа гэж бодож байтал хазаар ногт, чедэр тушаа ч үгүй тарган хээр морь гэрийн дэргэд хүрч ирээд тэр авгайд шууд хүрч очив. Авгай тэр моринд хувинтай цайгаа уулгаж, тавагтай идээгээ ам хүргүүлэв. Тэр морины гэдсээр эмээлжийн олмын ороор олойртох цагаан үс ургасныг үзвэл хээр морь урьд хатуу эдлэгдэж байсан бололтой боловч, одоо түү тарган, хур хүчтэй байхыг үзвэл хэдэн жил хүнд огт эдлэгдээгүй бололтой. Бас түүний урт дэлээс олон өнгийн хив торго намиртал зүүснийг үзвэл ямар нэг тэнгэр сахиусанд сэтэрлэсэн морь байна.

Нагацын эхнэр тэр моринихоо цааш явахад “Өлзийтийн хээр минь, өлзийгээ хайрла!” гэж хэлээд хойноо нь ааруул идээ цацаж байна. Хээр морь Өлзийт уулын эүг өвс татлан идсээр явчив.

Энэ юун морь болохыг асуувал энэ морини тухай нэг домогт явдлыг нагацын авгай надад ярьж өгев. Энэ домгийг хавь ойрын хүмүүс итгэдэг бөгөөд үнэн болсон хэрэг байжээ. Тэр авгайн ярьсныг сэтгэлдээ тогтоосны хирээр одоо гаргаж хэлье:

“Өлзийтийн хээр гэдэг энэ морь, их номхон боловч түүнийг хавь ойрын хүмүүс нэг ч барьж унадаггүй. Учир нь, энэ морь бол Өлзийт уулын зэний унадаг морь гэдэг юм.

Чухамдаа уулын эзнийг хээр морио унаад явж байхыг үзсэн хүнгүй боловч түүнийг уулын эзний морь гэж итгэх нэг шалтгаан гарсан юм" гэнэ.

Манай энд Цагаан-Очир гэж нэг хүн байсан юм. Түүний Үр хүүхэд ч, одоо ч хүртэл бий. Очир хав хар царайтай учраас түүнд нутгийн хүн хоч нэр өгч цагаан-Очир гэж нэрлэжээ. Цагаан-Очир нилээд олон адуутай боловч, түүний хамгийн хайртай нэг хурдан хээр морь байсан, тэр нь одоо саяны ирдэг хээр морь шүү.

Цагаан-Очир олон адуутай учраас олон жил дараалан Өлзийт уулын дэргэд өртөөний алба хийж байжээ. Тэгээд түүний хээр морь энд их нутагших, Өлзийт уулын орчим ямагт билчээрлэх заншив. Сурсан заншлыг сураар оосорловч дийлдэхгүй гэдэг үг бий шүү. Адуус амьтан ч гэсэн нэг газар нутагших заншвал түүндээ заавал эргэх болдог юм. Энэ хээр морь өвс билчээр сайн бол Өлзийт уулнаас огт холдоггүй, адуун сүргийг хайхрахгүй, ганцаар билчээрлэн явдаг болжээ. Хаалаа билчээр муудаж зуд болбол хээр морь айлини адуутай нийлж холын билчээрт гардаг. Тэгвэл хол газраас Өлзийт уулын бараа харагдах өндөр газрыг олж өглөө бүр Өлзийт уулаа харж нүдний нулимсыг унагааж байдаг болсон юм гэнэ билээ. Өлзийт уул өндөр биш боловч энэ тал нутагт хэдэн өртөө хол газраас ч сүүмэлзэн харагдана. Зуд өнгөрч цаг дулаармагц хээр морь ижлээ орхиж хамгаас түрүүнд Өлзийт ууландaa хүрч ирдэг юм.

Хээр морийг хүн унаад хол газар аваачаад тавьчихад нутагтгаа давхиад ирдэг байжээ. Урьд Цагаан-Очир өртөө хийж байхад ачаа юмгүй ганц элч ирвэл Цагаан-Очир хээр морио унуулаад элчийг улаачгүй ганцаар нь явуулдаг байжээ. Элч хээр морийг зэргэлдээ өртөөнд очоод сууллан тавимагц ухаант хээр морь гэдрэг өөрөө буцах ирдэг билээ. Энэ бол Цагаан-Очирт ашигтай учраас эзэн нь хээр морио улам хайрлах болжээ.

Нэг их шуурга болоход Цагаан-Очирин хамаг адуу уруудан явчихжээ. Адууг эргүүлэхээр хэдэн хүнийг хэдэн хоног явуулж арай гэж дутуу хагас олж ирсэн юм гэнэ билээ. Тэхэд хээр морь ч эрэл сурал гаргалтгүйгээр нэг азрага адууг дагуулан шуурга өнгөрсний нөгөөдөр нутагтгаа буцах иржээ. Энэ бол яаруу түргэн элч нарыг явгаруулахгүй, албыг хурдан залгамжлахад нь их тус болов. Хэдэн жил өнгөрсний хойно Цагаан-Очир өртөөнөөс халагдаж өөр тийш ийүүв. Гэтэл хээр морь ижлээ дагах явахгүй Өлзийт ууландaa үлдэв. Цагаан-Очир ганц морио дагах Өлзийт уулын ойр

нутаглах аргагүй байсан ба бас өртөөний шинэ хүмүүс олон малтай баялаг Очирынхыг өртөөний тайт нутаг билчээрт нутаглуулахгүй, хөөдөг байжээ. Ийм учраас Цагаан-Очир хэдийгээр хээр мориндоо хайртай боловч түүнийг шинэ өртөөний хүмүүст худалдъя гэвэл өртөөчин Очирыг боогдуулж хээр морийг хямдаар авахыг оролджээ. Тэхлээр Очир хээр морио өртөөчинд худалсангүй. Бас хавь ойрын хүмүүс хээр морины заншлыг мэдэх учраас худалдах авахгүй байв. Тэгээд Очир хээр морийг худалдах авах хүнийг эрж байтал Өлзийт уулын наадам болов. Тэр наадамд холын хушуунаас нэг бөх ирж барилдав. Тэр бөх, ирэх замдаа моринхоо хөлийг доголгосон тул унаж буцах морийг эрж байв. Очир түүнтэй тохиолдож сая түүнд хээр морио зохих үнээр худалдад. Тэр бөх хээр морины заншлыг мэдэхгүй, морини тарган сайнд бахдах овоо ч үнэ өгсөн юм гэнэ билээ.

Наадам тармагц тэр бөх хээр морийг унаад, доголон морио хетлөөд нутагтаа буцав. Нилээд хоносон хойно хээр морь Өлзийт ууландаа буцах ирэв. Тэр бөх олон өртөө алсалсан хол газраас ганц морийг эрж ирсэнгүй орхив. Тэхлээр хээр морь бас Очирынх болов.

Одоо Очир нэг санаа олж хээр морио холын хүнд худалдаад байвал ашигтай юм байна гэж мэдээд алсын аянчин, замын хүмүүс, эрэлчин нарт хээр морио хямд үнээр боловч дуртай худалдаг байв. Хээр морь хурдан сайн морь тул хэн ч дуртай авдаг байв. Хэд хоноод хээр морь ямагт буцах ирдэг учраас Очирт их ашигтай байжээ.

Аянчдыг мэхэлж хээр морио худалдсан тухай нутгийн хүмүүс элдвийн үг ярьдаг болов. Түүний нэг нь:

Очир хээр морио нэг аянчинд худалдсаны дараа хээр морь нь мэнгөлсөн сайхан эмээлтэй буцах ирсэн гэнэ. Морь нь ээний гараас алдуулан зугтаах ирсэн бололтой. Үнээс хойш Очирын шунахай сэтгэл улам хөгжих, хээр мориндоо унасан хүнийг булгиж хаях ба цулбуураа тасдааж уяанаас зугтах зэрэг муу занг сургажээ. Хээр мориндоо ийм муу зан сургаад Очир хээр морио дахин худалдах ашгийг их л олж байв.

Хээр морь алс Дариганга нутгаас нэг богц ачаатай зугтах ирсэн гэж хүн ярьдаг боллоо. Тэр богц ачааг замд нь хүн салгаж авахгүй, яж ирснийг мэдэх аргагүй, юу боловч хачин юм. Очирын эхнэр охид тэр жилийн наадамд урьд үзэгдээгүй тортон дээлийг өмсөх явсан. Хүний хэлэх нь тэр богцонд шинэ буулгах бэрийн өмсгэл хувцас байсан гэдэг.

Тэгээд хэдэн жил өнгөрсний хойно Өвөр Монголд самуун будлиан гараад манай нутагт буутай дээрэмчид нэвтэрч ирсэнд нутгийн хүмүүс зүг зүг тийшээ зугтах болов. Гэр малаа хаяад зугтсан ч хүн бий. Тэр үед манайханд хурдан буу тун ховор байсан; ганцхан Очир хурдан буутай тул дээрэмчийн нэгийг буудан алжээ. Ийм учраас дээрэмчид Очирыг заавал барьж авах гэж хөөв. Очир зугтахдаа хээр морио хамгийн хурдан морь гэж шилж унаад Мэнэнгийн шил рүү зугтсанд хойноос нь олон дээрэмчид морь сольж байгаад хөөсөн боловч огт гүйцсэнгүй. Хээр морь тийм хурдан морь юм. Очир хээр морины ачаар дээрэмчийн гараас гарчээ.

Гэтэл усгүй цэл Мэнэнгийн их талд хээр морь нь Очирыг өөрийн нь сургасан аргаар булгих хаяад Өлзийт ууландaa өөрийн зэний эмээлтэй буцах иржээ. Очир тэгээд сураг чимээгүй алга болсон юм.

Хэдэн жил болсны хойно, өвөл цас орсны дараа нутгийн айлууд Мэнэнгийн талд очиж өвөлжих байгаад нэг хонхроос Очирин хэлхээтэй яс, зэвэрсэн буу, хувхай ташуур гурав хэвтэхийг үзсэн юм гэнэ билээ.

Очирин дэргэд алд хиртэй ухсан хуурай худаг байсан гэдэг. Бодвол Очир буу ташуур хоёроороо худаг малтаж, ус гаргах уух санаатай оролдож байгаад чадалгүй цангаж үхсэн бололтой. Тэгээд шунахай Очирин намтар дууссан юм.

Түүнээс хойш хээр морь Өлзийтийн хээр нэртэй болоод олон жил нутагших байна. Нутгийн хүн Очирин үхсэнд харамсан гашууддаг боловч хайрт морио доромжилсны хохь гэж үзээд харин хээр морийг хайрлан цай идээнийхээ дээгийг барьдаг болсон юм.

Төрсөн нутагтадаа дурлах морины сайхан заншлыг буруугаар ашигласны үр Очирт ингэж туссан юм шүү.

(Ц. Дамдинсүрэн)

Notes:

1. уул/уулын,...: note how the author declines this word without an n-stem in the genitive case, but tends to treat it as an n-stem in the dative and ablative cases
2. арай гэж: 'barely managing, just barely'
3. эрэл сурал гаргалтгүйгээр: 'while the search (organized) was unsuccessful'

4. бэр буулгах: 'to take a bride; to bring a bride to one's house'
5. зүг зүг тийшээ: 'in every direction'
6. хурдан буу: 'repeater, automatic rifle'

LESSON 28

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

Нэгдүгээр бүлэг

Нийгэмлэгийн байгууламж

Нэгдүгээр зүйл. Бүгд Найрамдах Монгол Ард Улс бол эзэрхэг түрэмгий ба феодалын дарлалыг устгасан (малчид, ажилчид, сэхэээтэн) хөдөлмөрчдийн тусгаар тогтносон бөгөөд цаашид нийгэм журамд давшин орохын тулд тус орныг хөрөнгөтний бус замаар хөгжүүлэх явдлыг хангагч улс мөн.

Хоёрдугаар зүйл. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын улс төрийн үндэс бол феодалын байгууллыг унагааж, ард түмэн, улс төрийн эрхийг байлдан олж, феодалууд (хан, ван, гүн, тайж, хутагт, хувилгаад)-аас өргөн ард олонд учруулж байсан улс төр, эдийн засгийн дарлал мөлжил, эрх ямба, дур зоригийн эзэрхлийг устгасны үрээр өсч бэхжисэн хөдөлмөрчдийн депутат (ардын төлөөлөгчид)-ын хурлууд мөн.

Гуравдугаар зүйл. Бүгд Найрамдах Монгол Ард Улсад засгийн бүх эрх, хөдөлмөрчдийн депутатын хурлаар уламжлагдан, хот, хөдөөгийн хөдөлмөрчдийн мэдэлд байна.

Дөрөвдүгээр зүйл. Бүгд Найрамдах Монгол Ард Улс, хөрөнгөтний бус замаар хөгжих, цаашид нийгэм журамд давшин орох явдал бол Бүгд Найрамдах Монгол Ард Улсын аж ахуй, соёл, нийгэмлэгийн аж байдлыг улсын төлөвлөгөөний үндсэн дээр өөрчлөн зохиох явдлын биелэлтээр хангагдах үүнд тухайлбал:

Ардын хөдөлмөрч аж ахуйг бүхий л аргаар хөгжүүлэн сайжруулахад улсаас тэтгэх, хөдөлмөрчин ардын сайн дурын хамтарсан нэгдэлд улсаас туслах, машинаар өвс хадах, морин станцуудыг хөгжүүлэх, тус улсын дотор мал аж ахуй, аж үйлдвэр, харилцаа холбоо, тээврийг хөгжүүлэх явдлаар хангагдана.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын ардын аж ахуйн хөгжилт нь нийгэмлэгийн баялгийг нэмэгдүүлэх, хөдөлмөрчдийн материаллаг энх аж байдал, соёлын хэмжээг цуцалтгүйгээр өрнүүлэх, тус улсын үндсэний тусгаар тогтнол, батлан хамгаалах хүчийг бэхжүүлэх ашиг тусад тохирон биелэгдэнэ.

Тавдугаар зүйл. Бүх газар, түүний хөрсөн дорхи баяллаг, ой мод, ус, тэдгээрийн баяллаг, фабрик, завод, нийт уурхай, хүдрийн уурхай, алт боловсруулах явдал, төмөр зам, авто машиний хийгээд усан ба агаарын тээвэр, холбооны хэрэгсэл, банк, машинаар өвс хадах станц, улсын аж ахуйнууд бол улсын өмч буюу ард нийтийн хөрөнгө мөн. Эдгээрийг хувьдаа өмчилж болохгүй.

Зургадугаар зүйл. Ард иргэний мал, хөдөө аж ахуйн багаж, үйлдвэрлэлийн бусад багаж, түүхий эд, боловсруулсан үйлдэхүүн, орон сууц, хамаа барилга, гэр хогшил, хөдөлмөрийн орлого нөөцийг амин хувьдаа өмчлөх эрх, түүнчлэн амины өмчийг өвлөх эрхийг хуулиар хамгаална.

Долдугаар зүйл. Хоршооллын байгууллага, ардын нэгдлийн нийгэмлэсэн үйлдвэрийн газар, бүх тоноглол, багаж хэрэгслийн хамтаар, мөн тэдгээрийн боловсруулж байгаа үйлдэхүүн, түүнчлэн сайн дураар нэгтгэсэн хөрөнгө хогшил, мал, хөдөө аж ахуйн багаж, нийтийн барилга нь эдгээр хоршооллын байгууллага, ардын нэгдлийн нийтийн өмч болно.

Наймдугаар зүйл. Газар бол улсын өмч буюу ард нийтийн хөрөнгө мений тул билчээр буюу тариаланд ашиглуулах аар ард иргэн, түүнчлэн хөдөлмөрчдийн сайн дурын нэгдэлд үнэ төлбөргүйгээр олгогдоно.

Есдүгээр зүйл. Үнэнч шударгуу хөдөлмөр бол Бүгд Найрамдах Монгол Ард Улсын ардын аж ахуйн хөгжилт, батлан хамгаалах хүчний бэхжилт ба хөдөлмөрчдийн энх аж байдлын цаашдын өсөлтийн үндэс бөгөөд хөдөлмөрийн чадвар бүхий ард иргэн бүрийн хүндэт үүрэг мөн.

Хоёрдугаар бүлэг

Засаг төрийн байгууламж

Аравдугаар зүйл. Бүгд Найрамдах Монгол Ард Улсаас түүний засгийн дээд байгууллага ба төрийн удирдах, захирах байгууллагаар төлөөлүүлэн эрхлэх хэргүүд нь:

А. Олон улстай харилцах явдалд Бүгд Найрамдах Монгол Ард Улсаа төлөөлөх, бусад улстай гэрээ байгуулах ба батлах.

Б. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын дотоод бодлого, аж ахуй, соёлын хэргийг хөгжүүлэх явдлыг ерөнхийд нь удирдах.

В. Улсыг батлан хамгаалах явдлыг зохиож, зэвсэгт хүчийг удирдан, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тусгаар тогтнолыг хангах.

Г. Улсын хилийг тогтоох ба өөрчлөх.

Д. Байлдах, найрамдах асуудлыг эрхлэх.

Е. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын үндсэн хуулийг тогтоох ба түүний биелэлтийг хянах.

Ж. Тус Бүгд Найрамдах Улсын захиргааны хувиарыг тогтоох.

З. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын дотор оршин суугаа олон ястны улс төр, аж ахуй, соёлын хөгжилтийг тэдгээрийн үндэстний онцлог байдалд тохируулан хангах.

И. Улсын онц эрхийн үндсэн дээр гадаадтай худалдаалах, дотоодын худалдааны системийг удирдах.

К. Улсын аюулгүй байдал, ёс дэглэм ба ард иргэний эрхийг хамгаалах.

Л. Улс ардын аж ахуйн төлөвлөгөөг батлах.

М. Мөнгөний ба зээллэгийн системийг удирдах, улсын төсвийг батлах, албан татвар, хураамж хийгээд орлогыг тогтоох.

Н. Улсын банк, аж үйлдвэр, хөдөө аж ахуй, худалдааны газар, албан байгууллагуудыг удирдан захирах.

О. Улсын ба түүнчлэн нийгэмлэгийн даатгалтыг зохион байгуулах.

П. Гадаадтай зээллэг байгуулж батлах, дотоодын зээллэгийг гаргах.

Р. Холбооны байгууллага ба тээврийг удирдах.

С. Тус улсын байгалийн баялгийг хамгаалж ашиглах явдлыг зохион байгуулах ба газар ус, ой мод, билчээр хийгээд тэдгээрийн баялгийг ашиглах журмыг тогтоох.

Т. Мал аж ахуй, тариалангийн хөгжлийг зохион удирдах.

У. Жин хэмжүүрийн системийг тогтоох.

Ф. Улсын бүртгэл, тайлан ба тоо бүртгэлийг зохион байгуулах.

Х. Тус улсын зам барилга, орон сууцны ба хот суурини аж ахуй, түүний барилга, мөн хот сайжруулах ажлыг удирдах.

Ц. Ардын соёл боловсролын ба эрүүлийг хамгаалах явдал, шинжлэх ухаан, биеийн тамирын байгууллагыг удирдах.

Ч. Шүүх прокурорын байгууллагыг зохион байгуулах.

Ш. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын одон, медалийг тогтоох, түүгээр шагнах, хүндэт жуух бичгээр шагнах ба тус улсын хүндэт цол олгох.

Щ. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын харьяат иргэн болох тухай хууль тогтоох.

Э. Уучлал өршөөл үзүүлэх тухай тогтоол гаргах.

Арван нэгдүгээр зүйл. Бүгд Найрамдах Монгол Ард Улс бол Төв, Хэнтий, Чойбалсан. Дорноговь, Өмнөговь, Өвөрхангай, Архангай, Завхан, Ховд, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Увс, Говь-алтай, Баян-өлгий, Сүхбаатар, Дундговь, Баянхонгор аймгууд ба Улаанбаатар хотоор бурэлдэнэ.

Арван хоёрдугаар зүйл. Аймгууд захиргааны талаар сумдад хуваагдана.

Сумд нь цаашилж багуудад хуваагдана.

Улаанбаатар хот хороодод, хороод нь хорьдод хуваагдана.

Notes:

1. хангагдах үүнд: the verbal noun modifies үүнд (энэ)
2. хувьдаа (өмчилж): 'individually, privately'
3. сайн дураар: 'voluntarily'
4. мөний тул: 'because it is . . . '
5. тариаланд: 'as cultivated fields. . . '

LESSON 29

МОНГОЛ ОРОН МАНЖ УЛСАД ЭЗЛЭГДСЭН

17-18 дугаар зууны үеэр Төв Азийн уудам дэлгэр нутагт Баруун Монгол, Халх Монгол, Өвөр Монголын зэрэг феодалын улсууд байлаа. Халх ба Өвөр Монгол одоогийн хоо байгаа нутагт, Баруун Монгол нь Алтайн цаагуур тус тус нутаглаж байв. Тэр үеийн Монгол орон даяар феодалын бутрал түгээмэл поёлж, феодалын өөр хоорондын ширүүн тэмцэл тасралтгүй үргэлжилж байжээ. Нэгэнтэйгүүр феодалын улсууд хоорондоо сэтээ сэвээгүй дайн дажин хийж, нэгээйтэйгүүр тэдгээр улс тус бүрийн феодалуудын дунд эх захгүй эвдрэл мөргөлдөөн болж байв. Энэ бүхэн нь манжийн түрэмгийлэгчдээс Монгол орныг байлдан эзлэхэд аятай нөцхөл болсон байна. Гэсэн ч эрх чөлөө, тусгаар тогтолцоо хамгаалан баатарлагаар эсэргүүцэн тэмцсэн Монголын ард түмнийг эзлэн боолчлох нь тийм амаргүй хэрэг байлаа. Манж улс, Монгол орныг гартаа оруулан авахын тулд Монголын феодалын бутрал ба урвалтыг ашиглан даруй 150 гаруй жилийн турш асар их хүч хөрөнгийг сүйтгэж, үй түмэн цэргийнхээ амийг үрж, цусы нь асгаруулсан ширүүн харгис дайныг хийжээ.

Манжийн байлдан дагуулагчид, Монгол орныг эзлэх явдлаа Өвөр Монголоос эхэлсэн юм. 1624-36 онуудад манжийн түрэмгийлэгчид Өвөр Монголыг эзлэн боолчлох дайн хийжээ. Тэр үед Манж улс Азийн олон орон, түүний дотор Хятадын Мин улсын тусгаар тогтолцд аюул занал учруулж байв. Энэ үндсэн дээр Мин улс ба Цахарын хаант улс, нийтийн дайснаа дараахын тул холбоо байгуулж байв. Гэтэл Өвөр Монголын шар хар феодалууд уравсан ба Халх Монгол шийдвэртэй дэмжлэг үзүүлж чадаагүйн уршгаар 1636 онд Манжийн цэрэг Өвөр Монголыг эзлэн авч, тэнд өөрийн эзэрхэг цэрэг, нутгийн урвамтгай феодалуудыг засаглуулан суулгах зэргээр улс төрийн харгис ноёрхлоо тогтоов.

Өвөр Монголын зориг бадрангуй ард түмэн, Манжид эзлэгдсэний дараа ч гэсэн харийн боолчлогчдыг эсэргүүцхээ больсонгүй, харин уlam хүчтэй тэмцсээр байжээ. Жишээлбэл: 1643 онд Өвөр Монголд Сөнөдийн Тэнгис баатрын удирдлагын дор манжийн ноёрхлыг эсэргүүцсэн бослого гарч эрэлхгээр тэмцэх байжээ.

Манж улс цаашдаа Халх, Баруун Монголыг эрхэндээ оруулах зорилго тавьжээ. Тэр зорилгоо биелүүлэх явдлыг хөнгөвчлөхийн тулд Манж улс урьдаар Хятадыг эзлэхээр шийджээ. Их Хятадын ард түмэн, өөрийн гайхамшигт удирдагч Ли Цзы-чэн, эх оронч баатар Йо Фэй нарын удирдлаг-аар манжийн түрэмгийлэгчдийг баатарлаг эсэргүүцэн тэмцжээ. Тэр үед монголын ард түмэн, өөрийн их хөрш Хятадын ард түмний баатарлаг тэмцлийг талархан дэмжих байлаа. Манай ард түмэн “Хятадын их ард түмэнтэй аль хэдийнээс ах дүүгийн найрамдлын бат барилдлагаар холбоотой байдаг” байсан бегеед олон зуун жилээр үргэлжилсэн “Хятадын ард түмний эрх чөлөөний баатарлаг тэмцлийг ямагт асар ихээр талархан сайшааж...байсан юм”. Гагцхүү дотоодын харгис феодалын уравсны харгаагаар 1644 онд Хойт Хятад манжийн түрэмгийлэгчдэд эзлэгджээ. Энэ явдал, манжийн түрэмгийлэгчдээс Монгол орныг эзлэх гэсэн хорт бодлогоо биелүүлэхэд ноцтой дехөм болов.

Хятадыг эзлээд Манж улс, Монголыг Хятад ба ялангуяа Оросоос бүрмэсэн хөндийрүүлэн таслах бодлогыг урьд урьдыхаасаа улам хүчтэй явуулах боллоо. Гэтэл тэр үед Орос улсын гадаад бодлогын гол чиглэл нь баруун зүгт хандаж байсан учир Монголыг эзлэх зорилго тавиагүй, харин өөрийн дорнод хилийн агуулгүй байдлын учир Манж улсын байлдан дагуулах бодлогын эсрэг Монголчуудын нэгдэн тэмцэх явдлыг талархаж байжээ. Гэвч Монголын ард түмэн, тус оронд ноёрхож байсан феодалын бүтэцдэд улмаас харь манжийн түрэмгийлэгчдийн эсрэг хүч нэгдэн тэмцэх чадсангүй.

Монголын ард түмэн өөрийн орны тусгаар тогтолцоо тэмцэлд Орос улсыг түшиглэхийг оролдож байлаа. Ингээд Халх, Баруун Монголын зарим феодалууд, Орост Монголын дагаар орох тухай асуудлыг тавьж байжээ. Тэр тухай хэлэлцээрийг Их Хүрээний газар 1665 онд Оросын элчин Бубеный, 1666 онд Кульвенский нар тус тус хийж, мөн асуудлаар 1675 онд Халхын төлөөлөгчид Москва орж байжээ.

Манж улс, Монголын дотоод байдлын талаар түүний феодалын бутралыг улам гүнзгийрүүлээн хүчий нь сулруулж, нэгдэх явдлы нь хаах бодлого явуулж байв. Манжийн тэр, ялангуяа Халх, Баруун Монгол, Өвөр Монголын зэрэг Монголын ноёнт улсуудын феодалын хоорондын зөрчлийг санаатайгаар гүнзгийрүүлэн, тэдний дунд байнга яс хаяж байжээ. Манжийн эсрэг хүч нэгтгэн тэмцэх эрмэлзлэл тэр үед их гарч байжээ. Жишээлбэл: 1631-34 онуудад халхын Цогт тайж тэргүүтэй олон ардууд, манжийн түрэмгийллийг эсэргүүцсэн Өвөр Монголын ард түмэн, Лэгдэн хааны цэрэгт гар биеэр тусалж байжээ.

Түүнчлэн 1643 онд халхын зарим хушууд, Манжийн талхигдлыг эсэргүүцсэн Өвөр Монголын ард түмэнд цэрэг зэвсэг, хүч хөрөнгөөр тусалж байсан билээ. Түүгээр ч үл барам 1640 онд нийт Халх, Баруун Монголын феодалын чуулган болж, Манжийн эсрэг нэгдэн тэмцэхийн тул хэлэлцээ хийж Монгол-Ойрдын хуулийг баталжээ. Тэр чуулганаас хэрэв харийн түрэмгийлэгчидтэй хуйвалдан цэргий нь нутагтаа оруулсан буюу нутгаараа гаргасан ноёд тайж нар байвал эх орноосоо уравсан гэж хатуу хариуцлага хүлээлгэх тухай шийдвэр гаргасан байна. Ер нь Монголын ард түмэн, манжийн түрэмгийллийг хамгийн шийдвэртэй эсэргүүцэн тэмцэх байсан юм.

Гэтэл өөрийн ард түмний ангийн тэмцэл, үндэсний тусгаар тогтнолын хөдөлгөөний галаас үхтлээ айх байсан бөгөөд хувь хувши хичээсэн халхын шар хар феодалууд эх орноосоо уrvан тэрслэж Манжийн түрэмгийлэгчдэд төрөлх нутаг, ард түмнээс худалдах тийш хандаж байжээ. Монгол орныг Манжийн түрэмгийлэгчдийн эрх мэдэлд оруулах талаар Түшээт хан, Сайн ноён хан, Засагт хан нарын зэрэг урвагч харгис феодалууд бүхий л арга хэрэглэн ажиллаж байлаа. Ялангуяа дээр үеэс Манжийн түрэмгийлэгчдийн тагнуул төлөөлөгч болж байсан Жавзандамба хутагт тэргүүтэй харгис шар феодалууд Монголыг Манжид худалдах бодлого явуулж байв. Тэд Монголын ард түмнийг шашны харгис номлолоор муухруулж, улмаар манжийн хааныг залагдсан эзэн гэж манжийн түрэмгий бодлогыг үзэл сурглын талаар үндэслэж байв. Ийнхүү уdtal бэлтгэн, зохистой цаг үеийг хүлээж байсан Монголын шар хар феодалууд Манжийн түрэмгийллийг эсэргүүцсэн Баруун Монголын Галдан Бодигт хааны довтолгооноор далимдуулан, Монголын ард түмнээс нууцаар хуйвалдан 1691 онд Манжид Монголыг “дагаар” оруулав.

Ингэж 1691. онд Халх Монгол, улс төрийнхөө тусгаар тогтнолыг алдаад, Манжийн феодалуудын ноёрхолд олон зуун жил нэрвэгдэх болсон юм.

Notes:

1. үеэр: 'throughout the period of . . .'
2. өөр хоорондын: 'among themselves, internal'
3. сэтээ сэвээгүй: 'without sense of order, haphazardly'
4. нэгэнтэйгүүр...негеетэйгүүр: 'on one hand. . . on the other hand'
5. эх захгүй: 'without a point of departure, undisciplined, anarchistic'
6. түрэмгийлэгчдээс: see sections 4. 2. d and 15. 2.
7. гэсэн ч: 'however'
8. гартаа оруулсан...: 'in order to introduce. . . into its control' (lit.: 'into its own hands')
9. шар хар феодалууд: 'the religious and secular feudalists' (lit.: 'the yellow and black feudalists')
10. дэмжлэг үзүүлж: 'to give support'
11. чадаагүйн уршгаар: 'by the misfortune of not being able to'; note the position of the genitive suffix.
12. зэргээр: 'and by other means'
13. эрэлхгээр: 'manly, bravely'
14. (уравсны) харгаагаар: 'by reason of'
15. урьд урьдинхаасаа: '(ever more forcefully) than their former one'
16. дагаар орох: 'to recognize the suzerainty (of another nation over one's own); to become a satellite'
17. дээр үеэс: 'from former generations, from early times'

18. үхтлээ айж байсан: 'were frightened to death';
ҮХТЛЭЭ = ҮХТЭЛ plus reflexive suffix; note that the verb 'to fear'
requires the ablative case.

19. хувь хувна хичээсэн: 'striving separately, each for
his own interest'

LESSON 30

ХЭНЗ ХУРГА

Баян Донойн зарц Бадамын хүү Базар тоглоом байхгүй тул нагац аавын өгсөн хэнз цагаан хургатайгаа хамт гэрийнхээ гадна наадан сууна.

Хэнз хурга нь биеэ маажуулах ба идэх юм горьдох, Базарыг үргэлж дагадаг ажээ. Базар гэрт орж эхийнхээ буруу харах хооронд хойд авдрын дээр байсан цагаан өвгөн гэдэг шаазан хүний дүрсийг нуун авч ирээд “Энэ өвгөн аав одоо авд мордохдоо чамайг унах явах гэнэ” гэж цагаан өвгенийхэе хүзүүг утсаар оосорлож хэнз хурганы ууцан дээр унуулан бэлхүүсээр нь уяад арын чоныг авлаг гэж тавьж, дараа нь “Би шарга морио унаад урд биеийг угтан авлая” гэж аавын хулсан ташуурыг унах гэрийн өмнө талаар явтал ард нь тар гэх чимээ гарав.

Юу болов гээд эргэж үзвэл өнөөх авд мордсон цагаан өвгөн чинь темэр царил дээр унах хэдийн хагаран хоёр хэсэг болоод хэвтэнэ. “Ээ хеөрхий өвгөн аав та ингэж зенег болсноо мэдэхгүй авд мордох гэж дурладаг чинь юу билээ. Ай хэнз хурга чи үүнийг үзэв үү? Энэ өвгөн аав чинь цолцойсон том гэдэстэй тарган амьтан ямбалан суудаг байсан, харин гэдсэн дотор нь юу ч байхгүй хоосон юм. Хоосон гэдэс байхээ. Миний гэдэс бас ийм хоосон хөндий юм биш байгаа гэж гэдсээ дарлаж үзвэл хонхолзож байна. Хоосон байхаас зайлхагүй. Энэ өвгөн аавын толгой дотор юу байдаг бол хагалаад үзье. Энэ том дэнхэр толгой дотроос ус ч гарч болно, тос ч гарч болно. Базар боссоод хага цохих юм эрж явтал гэр дотроос Базарын эх Должин гарч ирээд “Ай Базар, цайгаа халуунд нь уу” гэв. Базар хагархай өвгөнөө хормойгоороо бүтээж гэмшсэн бололтой сууж байлаа. Должин Базарын дэргэд ирээд “Пэ, чи бурхнаа юунд хагалчихав” гэж ширүүнээр асуухад Базар: “Би хагалсан бишээ. Харин энэ өвгөн аав чинь хэнз хургыг унах анд мордоод өөрөө гэдсээ хагалчихсан

юм гэж эхийнхээ өөдөөс тунгалаг хар нүдээ талимаартуулан харагад Должин Базарын толгойг илбэж, “Иш хүү минь аав чинь мэдвэл чамайг зодно доо”. Энэ бурхнаа цавуугаар наагаад хойд авдрандаа хийчих!” гэв.

Үдэш болох үед гэрийн хойно морины хөлийн чимээ ба хүний бүгшин ханиах сонсогдож Базарын аав Бадам гэртээ орж ирээд “Ай Должин! Цаана чинь бүр муухай юм болж гүйцэж” гэхэд Должин навтас хийж нэхрийнхэе өмнөөс ширтэн хараад айсан байдалтайгаар асуусан нь:

“Юу болов? Ганц морий чинь чоно идчихэв үү?” Бадам “Үгүй, үгүй, чи битгий өлзий бусын юм солиор. Хар халзан хонь чинь баруун худагт унаад үхэж. Хамаг сэрг сээвс нь худгийн усыг буртаглаад бас хамар амаар нь цус цувж газар лусыг бузарласан байна” гэв. Бадам Должин хоёр ямар нэг бурхан тэнгэр буюу лус савдгаас айсан байдалтайгаар шивнэн ярилцах хоолоо идээд унтав.

Должингийн санаанд цагаан өвгөнөө өвдсэн ба худагт сэтэртэй хонь минь орж үхлээ. Энэ хоёр яв цав тохиолдсон нь лав нэг учиртай хэрэг боллоо гэж ихээр сэжиглэн айж байсны учраас тэр шене цагаан өвгөн гэдэг бурхан нь хүрч ирээд “Миний гэдсийг хэн хагалсан байна? Би түүний гэдсийг хагалж хариугаа авна” гэж ууртайгаар занаж байна гэж зүүдлэв. Маргаашийн өдөр эр, эм хоёулаа тун сэжигтэй болж хүү Базараас: “Чиний гэдэс өвдэх байна уу? Хорчигнох байна уу? Цэндийж байна уу?” гэж дахин дахин асуухад, Базарын гэдэс эв эрүүл байсан боловч Базар: “Гэдэс минь заримдаа хор хор гэж байна” гэв.

Эр эм хоёулаа Чүлтэм гэлэнд очих хэрэгтэй гэж хэлэлцээд Бадам тэр ламд очиж учир явдлаа айлтгасанд Чүлтэм шоо төлгөндөө үзээд: “Бурхны хөргийг өвдсэнээр үр хүүхдийн насанд цөв болох, газрын үндсэний усанд улаан цус холилдуулснаар лусын аймаг бузардаж яр боом өвчний шалтгаан болох тул Номон хан ба Богд уул хоёрыг тахих хэрэгтэй” гэж хэдэн зүлийн гүрим буулгасанд Бадам мөн Чүлтэмийг гүйж тэр номуудыг уншуулах болов.

Гуравдугаар өдөр Чүлтэм гэлэн Бадамын гэрт баруун хойно нь завилан сууж, хойморт нь бурхан тахилыг бэлтгээд хонх дамрыг барьж түвд хэлний номыг ушиж эхлэв. Бадам Чүлтэмийн заавраар бурхан тэнгэрт хэрэглэх шүүс бэлтгэх болж эхнэртээ хэлсэн нь: “Одоо бурхан тахихад нэг хонь хэрэгтэй боллоо. Энэ халуун намрын цагт бүдүүн хонио алалтай биш. Ганц хэнз хургаа төхөөрөхөөс

биш аргагүй болов. Бас энэ ламын барьцанд нэг хонио баривал ямар?” Должин “Хэнз хурганы эх нь майлаад сэтгэл зовоох болов уу? Хурганы хамт ердөө дөрвөн хонь байсан үүнээс нэг нь худагт унах үхээд, негеө хоёр нь бурхны шүүс ба ламын барьц болоод, гагцхан хоньтой үлдэх хэрэг үү? Хэнз хурга минь сайн мяраалсан юм” гэж байлаа.

Бадамын хүү Базар гадна хургатайгаа наадан суутал Бадам гялбагар цагаан тэмрэгтэй урт хутгаа бариад гарч ирэв. Бадам хэнз хургыг барьж аваад алахыг завдтал Базар орилин бархиран хургаа тэврээд аавын хормойноос барьж миний хургыг битгий ал гэж гүйхад Бадам Базарын цохыг үнсэн таалж “Хүү чи битгий зов. Энэ хурга чинь бурхны зоог болж хожим их жаргалтай явна” гэхэд Базар: “Аав аа! Манай бурхны гэдэс хагарсан тул тэр одоо хоол идэх чадахгүй болсон биш үү” гэв. Бадам хүүгийнхээ үгийг сонсоод томоогүй саналыг хайллан санаж байтал Должин гарч ирээд “Хэнз хургаа битгий алаа! Хэрэв хонь алах болбол бүдүүн хониноосоо алъя” гэв. Бадам гайхаж хургаа тавиад ламын өмнө очиж “Одоо намрын цагт тараг цагаа элбэг тул бурхан ба уулаа махгүйгээр тахиж болох уу?” гэж асуухад: “Уул овооны эзэн, бурхан тэнгэрийг урьж залж ирэхэд өргөл тахил хэрэгтэй л байх, за, гэсэн өөрөө л мэд” гэж ууртайхан хариулахад Базар хатавчинд зогсох лам Чүлтэмийг амандаа хараагаад уухилж байна. Лам багш минь шүүс бэлтэг гэх, ганц хүү минь битгий бэлтэг гэх ямар ацтай бэрх хэрэг билээ? гэж Бадам гайхаж сууна.

Гэнэт гадна морины туурай сонсдож нэг хүн ирэв. Хэн билээ гэсэнд хоёр жилийн урьд цэрэгт мордсон Бадамын дүү Ханд цэргийн албаны хугацаагаа дуусгаад буцах ирсэн ажээ. Бүгдээр баярлалдан золголдох сонин сайхан үгээ ярилцсаны эцэст хургыг алах эсэх тухай одоогийн болж байгаа ацтай хэргээ Хандад хэлсэнд тэр зөөлнөөр хэлсэн нь: “Биднээс хэн мах идэх гэж шаардах байгааг ольё. Бурхан уу, эсвэл хүн үү?” гэхэд Чүлтэм гэлэн их уурлах “Би дуртайдаа танайд ирсэн биш. Тахилын идээ харамласан та нар сайн болохыг би үзье” гэж занаж мордоод явчихав. Цэрэгт яваад ирсэн Хандын ачаар халzan хурга алагдсангүй тул Базар хүү хургаа нэгэн удаа тэвэрч хайрлаад тавив. Үүнээс хойш хүү Базар лам Чүлтэмийг хурга алах гэдэг лам гэж нэрлэдэг болов.

Бадам Должин хоёр цөв тохиолдох болно гэж сэтгэл зовсонд Ханд хэлэв. “Тэр цагаан өвгөн нь хятад газар маш нарийн шавраар бүтээн үйлдсэн хүний дүрс тул энэ бол амьтан биш, шавар мөн. Уурлах гэж байхгүй. Үнэндээ бурхан гэж байхгүй тул бурхан хоол иддэггүй, харин бурхны нэрийг бариад лам нар бид нарыг мөлжих амьдардаг юм. Ус цус хоёр холилдоход ямар ч гэм байхгүй. Ер уг бодисын улирал болно. Гадаад далайд байгаа загас тэр-гүүтэй тоо томшгүй амьтан мөн далайн дотроо үхдэг, төрдөг бөгөөд түүний цус усандaa уусахаас биш, яах билээ. Ус ба шороо хий гурав бол амьгүй бодис тул түүнд ямар ч лус гэх мэтийн эзэн байхгүй. Харин энэ нь бүхий амьд бодисын тэжээл болно. Уул ба уснаас айх явдал бол бид хувцас хоол хоёроос айсантай үлгэр нь адил юм. Зүүд гэгч бол хүний санаанд байгаа зүйл нь уитаж байгаа цагт үнэхээр болж байгаа мэт үзэгдэхийн нэр бөгөөд түүнд ямар ч сэжиглэх зүйл байхгүй. Хүний үзсэн бодсон мэдсэн юмаа зүүдэлдгээс биш, сэтгэлд ороогүй мэдээгүй юмаа зүүдлэх гэх огт байдаггүй. Жишээлбэл: Нисдэг онгоцыг огт сонсоогүй хүн бол агаараар нисэх онгоц нисч байна гэх огт зүүдлэхгүй. Харин ноднин жил манай үүгээр нисэх онгоц ниссэнээс хойш түүнийг зүүдэлсэн хүн байж болох биз” гэв.

Түүнээс хойш тэр нэгэн өрхөөр бурхан тэнгэр ба уул ус гэдгийг тахихаа зогссон боловч гэр хотлоороо амаржамар аятай сайхнаар амьдарцгаасаар байна.

(Ц. Дамдинсүрэн)

Notes:

- буруу харах хооронд: ‘while (she) was looking the other way’
- дарлаж үзвэл: ‘when (he) tried pressing down’; үзэх is here used as an auxiliary verb with the imperfect converb (see section 12.17); for the conditional converb see section 9.3
- хоосон байхаас зайлхагүй: ‘there is no getting away from the fact that it was empty’
- бишээ: the final long vowel is only for emphasis
- эв эрүүл: ‘completely healthy’

6. алалтай: 'one must kill'; the suffix -лтай/-лтэй expresses necessity
7. төхөөрөөс биш аргагүй болов: 'there was nothing to do but, there was no choice but to. . .'
8. . . .алах болбол: 'If we must kill a sheep. . .'
9. гэсэн ч өөрөө л мэд: 'However, you make up your own mind; you do as you see fit'
10. амандaa: 'under his breath' (lit.: 'in his mouth')
11. алах эсэх: 'to kill or not'
12. дуртайдаа: 'by my own wish'
13. гадаад далай: 'the ocean' (lit.: 'the outer sea')
14. . . .уусахаас биш, яах билээ: 'there is no other way but. . . , how could it be otherwise. . . '
15. манай үүгээр: 'through our region' (lit.: 'through this ours'.)
16. амар жамар: 'peacefully and calmly'
17. амьдарцгаа(саap): pluritative form of амьдрax
18. гэр хотлоор: 'the whole family'

GLOSSARY

-A-

аав	daddy, father	автономит	autonomous
аажмаар	slowly, quietly, calmly	авхай	young lady, damsel
аалз(ан)	spider	авчрах	to bring
аалзны шүлс	spider web	араар	air, atmosphere; fir- ament
ааруул	a type of dry cottage cheese, dry cheese curds	арсагнах	to brawl, to rage; to bluster, to be boisterous
аарцаг	pelvis	агуй	cave
аашлах	to behave (in a certain way); to show one's charac- ter; to curse, to swear	агуу	great, grandiose; vast
ав	chase, battue	агшин	moment, instant
аваачих	to take away, to bring away	адил	like, as
авах	to take, to get	адуу(н)	herd of horses; horse, horses
авгай	married woman, wife; elderly woman	адуус	animal
авдар	trunk, chest	аж	амьдрал life, existence
авиа(н)	sound	аж	ахуй economy, management, householding
авирах	to climb	аж	байдал existence, life, way of life, living conditions
авлах	to hunt in a battue, to go hunting	аж	үйлдвэр industry
аврага	giant, champion wrestler; champion	ажиг	conspicuousness; attention, notice
аврагч	saver, saviour	ажиглах	to observe, to scrutinize
аврах	to save	ажил	work
авто машина	automobile	ажиллагаа(н)	work, activity
автобус	bus	ажиллах	to work, to perform labor
		ажилтан	laborer, workman
		ажилчин	worker

ажих	to observe, to notice	алд	fathom
ажээ	was, were	алд(ад)	(postpositional) approximately, nearly, just about
Ази	Asia	алдарт	illustrious, famous, popular
азрага	stallion	алдаршиг	to become known, to become famous, to be illustrious
ай	oh! hey!	алдах	to lose
айл	group of yurts; family, household; yurt, domicile; neighborhood	алдуулах	to cause to lose, to cause to let go
айлтгах	to report, to announce	аливаа	any, each, every
айлчлах	to visit, to go for a visit	алс	distant, remote; distance
аймаг	state: largest administrative division in the MPR; tribe, clan; category, class; sphere of influence	алс холын	distant
аймшиггүй	fearless, brave	алслах	to be distant, to be remote; to traverse
айсуй	comes, approaches	алсын	distant, from far away
айх	to fear, to be afraid	алт(ан)	gold; golden
айхавтар	strange; terrible; frightfully, terribly	Алтай	the Altai mountains
айхтар	see айхавтар	Алтан Булаг	town in N. Mongolia
алагдах	to be killed	Алтан Гадас	the North Star, the Pole Star
алах	to kill	алхаа	step, walk, gait
алба(н)	official duty, service; tax; corvée; official, formal	алхах	to step, to stride, to walk
албан татвар	tax	алчихах	intensive of алах
албан хаагч	employee; servant	алчуур	piece of cloth, shawl
албат	subject, subject to corvée duty; serf, slave	аль (алин)	which, any
алга	there is not, does not exist, is lacking	аль	give! (imperative)
алга болох	to disappear	ам(ан)	mouth; aperture, opening; oral
алгадах	to slap	ам заавар	oral instruction(s)
алгуур	slowly, quietly	ам хүргүүлэх	to let taste, to cause to taste

аман яриа(н) colloquial speech, oral tradition	амъд alive, living
амар peaceful, happy; peacefully, happily, easy	амъдрал life, existence, living
амар мэндээ мэдэлцэх to exchange greetings	амъдрах to live, to exist, to subsist, to make a living
амарлингүй indifferent, unconcerned; undisturbed, tranquil, calm	амъсгаа breathing, respiration; sigh, gasp
амархан easy, simple; easily, simply	амъсгаадах to pant, to puff, to gasp for breath
Америкийн Нэгдсэн Улс U.S.A.	амътан creature, living creature
амжилт success, result	ан(г) wild animals, game; hunting
амжилттай successful; successfully	ан гэрээ хийх to hunt, to go hunting
амжих to succeed, to manage to do; to do on time, to be on time	ангиг class; section, unit
амжуулах to complete, to produce; to cause to do on time	ангийн тэмцэл class struggle
амины personal, individual	андах to err, to make a mistake
амраах to let rest, to put at ease	анх at first, in the beginning; originally
амралт rest, vacation	анхдугаар first
амрах to rest	анхны primary, elementary, beginning
амрыг эрэх to greet, to welcome	арп back side, shady side; northern side; back, spine; north; northern
амсах to taste, to try	араатан carnivorous, predatory
амсхийх to rest a bit, to take a little rest	арав (арван) ten
амтлах to flavor, to season	аравгар саравгар spread out; bristling
амь (амин) life; spirit; breath	арай barely, scarcely, narrowly, almost
амь бие life	арай чарай somehow, with difficulty, just barely
амь тавих to wish for ardently; to give oneself entirely (to attain something)	арайхийх to manage to do somehow, with difficulty, just barely
	арга means, expedient, way out; trick, stratagem

аргадах	to coax, to wheedle	асгараах	to run out, to be poured out; to flow, to stream
аргал	dung, dried dung	асгаруулах	to cause to flow
аргалах	to find a means, to find a way; to heal; to contrive, to scheme	асграх	to pour out, to cause to spill out, to spill, to run out
аргалчин	a gatherer of dried dung for fuel	асгуулах	to cause to spill, to make (someone) spill
ард	common herdsman, worker, commoner, 'arat'; people, the people; behind, in back	асуудал	question, problem
ард нийтийн	general, public	асуулт	question
ард олон	the masses, the people	асуух	to ask
ард түмэн	people, people's masses	атгагдах	to be squeezed in the fist
ардууд	plural of ард	аттуулах	to cause to grasp, to cause to squeeze in the fist
ардын	of the people, people's, national	аугаа их	great, mighty
арилах	to clear up, to get clean; to disappear, to vanish	ах	elder brother
армы	army	ах дүү	brothers, sisters, brothers and sisters
артель	craftsman's shop, atelier, studio	ах дүүгийн	fraternal, brotherly
арчих	to wipe, to clean	ахих	to repeat
аршаан	holy water, heavenly nectar	ахлагч	senior, chief
арьс(ан)	hide, skin	ацтай	ambiguous, contrary; two-pronged
арын	northern; of the rear, of the northern slope (of mountains)	ач	merit, benefit, favor
асап	very, greatly, completely; extraordinary	ач хүү	grandson (son's son)
асах	to catch fire, to ignite, to burn; to come on (of lights)	ачаа(н)	load, freight
		ачаа буулгах	to unload
		ачих	to load
		амиг	profit
		амиг тус	profit, gain, advantage; utility
		амиглах	to make use of, to exploit; to take advantage of

ашиглгуулах	to cause to exploit, to cause to make use of	аяа	oh! alas!
ашигтай	profitable, advantageous	аяар	quietly, softly; slowly
аюул занал	menace, threat	аяга	cup
аюулгүй	not dangerous, safe, secure	аялгүү	dialect
аюултай	frightful, terrifying	аян	journey, trip
ая	situation, condition, opportunity	аянчин	traveller
		аятай	comfortable, pleasant; convenient
		аятайхан	pleasant, good, nice; pleasantly, nicely

-Б-

ба	and	багачууд	small children
баавгай	bear	багтарчих	(intens.) to lose consciousness
баагиулах	to cause to smoke, to cause to smoke in clouds	багтах	to fit in, to squeeze in, to go in
баасан	Friday	багш	teacher
баатар	hero; heroic	багшлах	to be a teacher, to teach
баатарлаг	heroism; heroic; heroically	бадраңгүй	flourishing; enthusiastic
баахан	rather, sufficiently, considerably; rather much	байгалийн баялаг	natural resources, natural wealth
бааш	pretence, simulation; deception	байгаль	nature
баг	the basic administrative unit in the M. P. R.	байгуулагдах	to be organized, to be instituted, to be constructed
бага	small, little; junior; childhood	байгууламж	structure, organization
бага нас(ан)	childhood	байгууллах	to organize, to construct
багаж	instruments, tools, inventory	байгууллага	organization; institution, establishment
багалзур	throat, gullet	байдал	state of being, condition, situation; outward appearance, air, aspect
багалзурдмаар	fit to choke, chokable		

байлгүй (in most contexts): it must be that...	барагдуулах to exhaust, to wear out
байлдаа(н) battle	барагцаалбал approximately, if one measures approxi- mately
байлдан дагуулагч conqueror	
байлдан дагуулах to conquer, to vanquish	
байлдах to battle, to fight a war	барам see үл
байн байн often, constantly; from time to time	барах to finish, to terminate; to consume
байнга constantly, regularly	бараахгүй not only... but
байр apartment; position, situ- ation; abode, dwelling place	баргил rough, hoarse
байтугай not only that, but...	бардам proud, conceited, vain
байх to be, to exist; to occur; to stop, to discontinue	бардах to boast; to be haughty
байцаагч inspector, revisor	барзгар uneven, rough, wrinkled
байшин(г) building	барилга construction, building, structure
балжуур eraser	барилдах to wrestle, to grapple
балмад outcast; madman; cruel, brutal, beastly	барилдлага tie, bond, connection
бандан(г) bench, cot	баримт proof, demonstration; argument; fact, circumstance
бандид pundit, pandita	баримтлах to hold to, to follow, to take as one's guide
банз(ан) board	барих to hold, to grasp, to seize; to catch, to take; to offer, to treat; to build
банк bank, banking	баруун west; western; right
бар tiger	бархирах to scream, to howl, to roar, to bellow
бараа outline, silhouette (in the distance)	барьц(ан) gift, offering, dona- tion
бараа бологч member of retinue, courtier	бас also, too; again
бараагүй болох to disappear completely, to go out of view	бат firm, steady
бараалхах to have an audience with (+ dative)	баталгаа confirmation, guaran- tee, assurance
барааны саван household soap, laundry soap	батлах to confirm, to ratify; to strengthen, to reinforce
бараг nearly, almost	

бах	rapture; admiration; joy; pride	билүүдэх	to sharpen
бахдах	to be delighted, to be pleased	бийчээр	pasture, pasturage
бачимдах	to become confused, to lose one's head, to fidget	бийчээрлэх	to graze, to pasture
бачит	cunning, sly, crafty	билээ	was, were
баяжих	to become rich	битгий	don't
баялаг	wealth, riches; rich, wealthy	бичгийн сав	briefcase
баян	rich; wealthy person, rich man	бичиг	writing, script; document; book; letter
баярлалаа	thank you	бичиг үсэг	reading and writing, literacy
баярлах	to be happy, to be delighted	бичигдэх	to be written, to be recorded
баяртай	good-bye	бичих	to write
би	I	биш	not, is not
бид	we	бишгүүр	pipe, flute
бие	body; health; stature; one's self; side, shore	богд	saint; holy, divine; appellation of reincarnate lama
биенейн тамир	physical education	богино	short
биелүүлэх	to bring about, to fulfill	богинохон	shortish, rather short
биелэгдэх	to be fulfilled, to be realized	богц	saddle bag
биелэлт	fulfillment, realization, accomplishment	бодвол	apparently, obviously
